

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГИЙН ТӨЛӨВЛӨЛТ,
ГҮЙЦЭТГЭЛД ТАВИХ ШАТ ШАТНЫ ХЯНАЛТЫГ ҮР ДҮНТЭЙ ХЭРЭГЖҮҮЛЖ
ЧАДАХГҮЙ БАЙГААГААС ТӨСВИЙН ХӨРӨНГИЙН ҮР ӨГӨӨЖ БУУРСААР
БАЙНА

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН БҮРДҮҮЛЭЛТ,
ЗАРЦУУЛАЛТ, ҮР НӨЛӨӨ, ҮР ДҮН

АУДИТЫН КОД: ГСА-2025/31-6-ШТА-ГА

Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа, Утас: 70543156
Цахим хаяг: Sarantuyab@audit.gov.mn
Аудитын менежер: Г.Наранбаяр, Утас: 70543179
Цахим хаяг: Naranbayarg@audit.gov.mn
Ахлах аудитор: Б.Дарханбат, Утас: 70543179 Цахим
хаяг: Darkhanbatb@audit.gov.mn
Ахлах аудитор: Б.Анхтуяа, Утас: 70543179
Цахим хаяг: Ankhtuyab@audit.gov.mn
Аудитор: С.Батцэцэг, Утас: 70543179
Цахим хаяг: Battsetsegsa@audit.gov.mn
Аудитор: Б.Соёлмаа, Утас: 70543179
Цахим хаяг: Soyolmaaba@audit.gov.mn

Говьсүмбэр аймаг

2025

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт
мэдээллийг дараах хаягаар авна уу. Цахим хуудас:
www.audit.mn

Тайланг бэлтгэсэн:

Говьсүмбэр аймаг дахь
Төрийн аудитын газар

Дарга, тэргүүлэх аудитор
Б.Сарантуяа

Аудитын менежер
Г.Наранбаяр

Ахлах аудитор
Б.Дарханбат

Б.Анхтуяа

Аудитор
С.Батцэцэг
Б.Соёлмаа

Аудитын тайлан,
дүгнэлттэй холбоотой
асуудлаар нэмж тодруулах,
асууж лавлах зүйл байвал
70543156, 70543179
дугаарын утсаар харилцана
уу.

ХАЯГ:

Сүмбэр сум 3-р баг,
Нутгийн удирдлагын
ордон, 205 тоот

2025 оны 6 дугаар сар

ТОВЧИЛСОН ҮГС 2

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг Төсвийн тухай хуульд заасны дагуу бүрдүүлж, сумдад хуваарилсан байна. 7

1.1 Улсын төсвийн орлогын бүрдүүлэлтээс шалтгаалан аймаг, сумдын ОНХС-д олгох орлогын шилжүүлэг 3.7 хувиар дутуу олгогдсон байна. 7

1.2 Сумын ОНХС-ийн төлөвлөлтийг хийхдээ иргэдийн санал аваагүй 1,170.3 сая төгрөгийн 13 төсөл, арга хэмжээг төлөвлөж батлуулсан байна. 9

2.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний зорилтод үр дүн 75.4 хувьтай байна 14

2.1. ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний 84.3%-д гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер зохион байгуулсан байна. 14

2.2 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 3,046.0 сая төгрөгийн 11 төсөл, арга хэмжээний чанар үр дүн хангалтгүй, үр өгөөж буурсан байна. 17

2.3. ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон хөрөнгө оруулалтын ажлуудад ашиглалт, хадгалалт, хамгаалалтгүй хөрөнгүүд бий болсон байна.24

3. ОНХС-гийн үйл ажиллагаанд тавих хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүй, иргэд олон нийтэд ил тод тайлагнаагүй байна. 27

. 27

3.1 Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэлийн явцад хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлж ажиллаагүй байна 27

3.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-ний мэдээллийг Удирдлага мэдээллийн системд ил тод бүрэн тайлагнаагүй, хэрэгжилтийн тайланг холбогдох байгууллагад хүргүүлээгүй байна. 30

Дүгнэлт

Зөвлөмж

Дээд шатны байгууллагад хүргүүлэх санал

Шалгагдагч байгууллагын санал тайлбар

Тайлан баталгаажуулах тушаал

Тайлангийн хавсралтууд

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АИТХ	Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурал
АМ	Ашигт малтмал
АМНАТ	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
АМАТЗ	Ашигт малтмалын ашигласаны тусгай зөвшөөрөл
АОНХС	Аймгийн орон нутгийн хөгжлийн сан
АМХТЗ	Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИНХ	Иргэдийн нийтийн хурал
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МУЗЗНДНТУТХ	Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай
НАТ	Нөөц ашигласны төлбөр
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СХАА	Санхүүгийн хяналт аудитын алба
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ТА	Тогтвортой амьжиргаа
ТАХ	Төсөл арга хэмжээ
ТББ	Тендерийн баримт бичиг
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
УБТЗ	Улаанбаатар төмөр зам
УМС	Удирдлагын мэдээллийн систем
ХААГ	Худалдан авах ажиллагааны газар
ХБТХОХ	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс
ХО	Хөрөнгө оруулалт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Аудит хийх үндэслэл,
бүрэн эрх:

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторов 2024 оны “Аудитын сэдэв батлах тухай” А/107, “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/108 дугаар тушаалуудыг тус тус үндэслэн байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын нэгдсэн төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу аудитыг гүйцэтгэлээ.

Аудитын зорилт:

“Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө”-т байдалд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт, зөвлөмж гарган, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдсэн.

Аудитад ашигласан
шалгуур үзүүлэлт:

- Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль, түүнд оруулсан нэмэлт өөрчлөлт
- Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”
- Засгийн газрын 2023 оны 457 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлгийг тооцох аргачлал”
- Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”
- Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”
- Барилга, байгууламжийн батлагдсан зураг төсөв, ТЭЗҮ, магадлалын ерөнхий дүгнэлт, байгуулсан гэрээ болон бусад холбогдох эрх зүйн актууд.
- Бусад холбогдох хууль, эрх зүйн актууд

Аудитын хамарсан
хүрээ:

Аудитад аймаг, сумдын ИТХ, ЗДТГ, ХБТХОХ, СТСХ, СХДАА, ГХБХБГ, ХААГ, ОНӨГ, Багийн ИНХ, Засаг дарга, аймаг, сумдын орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны орлогын бүрдүүлэлт, хуваарилалт болон хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүжилт, хяналт, тайлагналтай холбоотой үйл ажиллагааг хамруулав.

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС-100, 300, 3000-3200, Монгол Улсын Төрийн аудитын стандарт 6817-3:2020, 6817-5:2020, 6817-7:2020, Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам болон MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудит, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандартын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг үндэслэн тулган баталгаажуулалтыг хийж, тухайн асуудал хариуцсан албан тушаалтнаас асуулга лавлагаа, тодруулга авах зэрэг горимыг хэрэгжүүлж, аудитын

Аудит хийх багийн
бүрэлдэхүүн,

Аудитын хугацаа:

Хүндрэл бэрхшээл:

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

асуудлын шинжилгээ болон арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, түүнд үндэслэн аудитын дүн, дүгнэлт, зөвлөмжийг боловсруулав.

Аудитыг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Б.Сарантуяа удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Г.Наранбаяр хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Дарханбат, Б.Анхтуяа, аудитор С.Батцэцэг, Б.Соёлмаа нар хийж гүйцэтгэлээ.

Аудитын нээлтийг 2025 оны 04 дүгээр сарын 29-нд хийж, гүйцэтгэлийн үе шатны ажлыг 2025 оны 05 дугаар сарын 05-ны өдрөөс 6 дугаар сарын 13-ны өдрийг хүртэл хэрэгжүүлж, тайланг 06 дугаар сарын 25-ны дотор боловсруулан, тайланг дарга, Тэргүүлэх аудиторовн тушаалаар баталгаажуулан холбогдох байгууллага албан тушаалтанд 2025 оны 07 дугаар сарын 01-ний өдөр хүргүүлжээ.

Тус аудитыг сүүлийн хагас жилд гүйцэтгэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан боловч аудитын төлөвлөгөөний хугацаанд өөрчлөлт орсон, Төрийн аудитын байгууллагын эхний хагас жилийн тайлан, мэдээний цаг хугацаатай давхардсан нь ажлын ачааллыг нэмэгдүүлсэн, цаг хугацааны хязгаарлагдмал байдлыг үүсгэсэн.

Говьсүмбэр аймагт Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас ОНХС-д олгох орлогын шилжүүлэг 6,357.6 сая, малын тоо толгойн албан татварын орлого 163.1 сая, өмнөх оны үлдэгдлээс санхүүжих 2,367.7 сая, бусад эх үүсвэрээс 965.3 сая, нийт 9,853.7 сая төгрөгийн орлогыг төлөвлөж, гүйцэтгэлээр 9,511.0 сая төгрөгийн санхүүжилтийг бүрдүүлжээ.

Аймаг, сумын ИТХ-ын тогтоолоор 9,853.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 114 хөтөлбөр, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд шинээр хэрэгжих 9,142.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 101 хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 8,643.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 91 ТАХ-нд 8,283.3 сая төгрөгийн гэрээ байгуулсан байна.

Худалдан авах ажиллагаа зарласан боловч шаардлага хангасан гүйцэтгэгч шалгараагүй 434.3 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 5, худалдан авах ажиллагаа зарлаагүй 100.0 сая төгрөгийн 1, шууд худалдан авалт зохион байгуулах боломжтой 72.0 сая төгрөгийн 5, нийт 506.1 сая төгрөгийн 10 хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний худалдан авалт амжилтгүй болсон байна.

Дүрслэл товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	ОНХС-ийн эх үүсвэр	8
Дүрслэл 2	Аймгийн ОНХС-ийн орлогын шилжүүлгийн тооцоолол	9
Дүрслэл 3	Орон нутгийн хөгжлийн санд нэмсэн орлогын эх үүсвэр	10
Дүрслэл 4	Ажлын хэсгийн эрэмбэлсэн саналыг сумдаар задалж харуулбал	11
Дүрслэл 5	Иргэдийн санал аваагүй ТАХ-ний жагсаалт	12
Дүрслэл 6	Аймаг, сумын Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдаагүй	13
Дүрслэл 7	ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн чиг үүрэг	14
Дүрслэл 8	Тендер шалгаруулалтын ажлын баримтын бүрдүүлэлт	18
Дүрслэл 9	Хөрөнгө оруулалт хийгдсэн салбарын ангилал	23

Хүснэгтийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Сумын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийн тооцоолол	8
Хүснэгт 2	Сумдын ОНХС-ийн санхүүжилтийн төлөвлөгөө, гүйцэтгэл	8
Хүснэгт 3	Багийн ИНХ-д оролцож санал өгсөн иргэдийн тоо	10
Хүснэгт 4	ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр баталсан хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний жагсаалт:	11
Хүснэгт 5	“2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-тэй уялдаа	12
Хүснэгт 6	Тайлант хугацаанд гэрээ байгуулсан ТАХ-ний худалдан авах ажиллагааг сонгон шалгаруулалт	14
Хүснэгт 7	ОНХС-ийн төлөвлөгөөний хэрэгжилт	17
Хүснэгт 8	Тайлант онд бүрэн хэрэгжсэн ТАХ-ний зориулалтын дагуу ашиглаж байгаагаар харуулав.	26
Хүснэгт 9	Санхүүгийн хяналт, дотоод аудитын газраас ОНХС-гийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалт	27
Хүснэгт 10	Захиалагчийн хяналтын мэдээ	28
Хүснэгт 11	Өмнөх аудитөөр өгсөн аудитын шийдвэрийн хэрэгжилт /аймаг,сумдаар/	29
Хүснэгт 12	УМС-д мэдээлээгүй зөрчлийг аймаг, сумдаар задалж харуулбал	31

Зураг товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Зураг 1	Сүмбэр сумын 1 дүгээр сургуулийн фасад засвар, спорт заалны дотор их засвар	19
Зураг 2	Авто замын ус зайлуулах хоолой, шугамын жил	19
Зураг 3	Хуучин 2-р сургуулийн хичээлийн 2-р байрыг дотуур байр болгон засварлах	20
Зураг 4	Шивээговь сумын сургуулийн спорт залны их засвар	21
Зураг 5	Шивээговь сумын Төрийн албан хаагчдын амьдрах орчин нөхцлийг дэмжих /байр засварлах/	22
Зураг 6	Шивээговь сумын 1-р багт хийгдэх нийтийн биеийн тамирын талбай байгуулах	22
Зураг 7	Баянтал сумын 154-р байрны дээврийн засвар ажил	23
Зураг 8	Баянтал сумын Спорт заалны барилга шинээр барих суурийн ажил	23

БҮЛЭГ 1**1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг Төсвийн тухай хуульд заасны дагуу бүрдүүлж, сумдад хуваарилсан байна.****1.1 Улсын төсвийн орлогын бүрдүүлэлтээс шалтгаалан аймаг, сумдын ОНХС-д олгох орлогын шилжүүлэг 3.7 хувиар дутуу олгогдсон байна.****1.1.1 ОНХНС-ийн эх үүсвэрийг хуульд заасан эх үүсвэр тус бүрээр бүрдүүлсэн байна.**

Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар ОНХНС-аас Говьсүмбэр аймагт олгох орлогын шилжүүлгийг 6,704.8 сая, төсвийн тодотголоор 295.5 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 7,000.3 сая төгрөгөөр тус тус баталсан байна. ОНХНС-г эх үүсвэр тус бүрээр дэлгэрэнгүй харуулбал,

Дүрслэл №01 ОНХНС-гийн эх үүсвэр

Эх сурвалж: Сангийн яамнаас ирүүлсэн аймгийн ОНХНС-ийн эх үүсвэрийн мэдээлэл

Төсвийн тодотголоор ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг 295.5 сая төгрөгөөр нэмэгдүүлж баталсан ба бусад эх үүсвэрийн дүнд өөрчлөлт ороогүй байна.

1.1.2 Улсын төсвийн орлого бүрдүүлэлтээс шалтгаалан аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлэг 6.5 хувиар дутуу санхүүжсэн байна.

Сангийн яамнаас аймгийн ОНХС-ийн төсвийн төслийг авч хянадаггүй бөгөөд ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг аргачлалын дагуу тооцож хуваарилсан байна.

Дүрслэл №02 Аймгийн ОНХС-ийн орлогын шилжүүлгийн тооцоолол /сая төгрөгөөр/

ОНХНС-аас аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг итгэлцүүрээр хуваарилагдах дүнгийн 50 хувиар буюу 2,398.3 сая төгрөгөөр тооцсон байна. АМХТЗ-ийн төлбөрөөс 12.5 сая, АМАТЗ-ийн төлбөрөөс 70.7 сая төгрөг хуваарилагдсан байна.

Аймгийн ОНХС-д хуваарилсан орлогын шилжүүлгээс Баянтал сумын ОНХС-д 550.1 сая төгрөгийг хуваарилсан ба аймгийн ОНХС-д 1,931.4 сая төгрөг баталсан байна.

Улсын төсвийн орлогын бүрдүүлэлтээс шалтгаалан 120.9 сая төгрөг буюу 6.5 хувиар дутуу санхүүжсэн байна.

Эх сурвалж: Сангийн яамнаас ирүүлсэн орлогын шилжүүлгийн суурь тооцоолол

1.1.3 Улсын төсвийн орлого бүрдүүлэлтээс шалтгаалан сумдын ОНХС-д олгох орлогын шилжүүлэг 2.7 хувиар дутуу олгогдсон байна.

Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.2¹, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 230 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлэг тооцох аргачлал”-д зааснаар аймгийн ОНХС-аас сумдын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг тооцохдоо орон нутгийн хөгжлийн индекс, хүн амын тоо, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээ зэрэг шалгуур үзүүлэлтийг үндэслэн тооцсон байна.

Сангийн яамнаас аймгийн ОНХС-аас сумын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийн суурь тооцооллыг 4,518.9 сая төгрөгөөр хянаж ирүүлсэн ба аймгийн ОНХС-аас нийт 5,068.9 сая төгрөгийг сумдад дараах байдлаар хуваарилсан байна. Үүнд:

Хүснэгт №01 Сумын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийн тооцоолол /сая төгрөгөөр/

Сумын нэр	Сангийн яамнаас ирүүлсэн тооцоолол					Аймаг баталсан	Зөрүү
	Өмнөх жилийн төлөвлөлт, зарцуулалт, үйл ажиллагааны үнэлгээ /ЖГҮ/	АМ-ын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр	АМ-ын ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр	ОНХС орлогын шилжүүлэг /итгэлцүүр/	Нийт дүн		
Сүмбэр	317.3	0.06	35.7	2,068.5	2,421.6	2,421.6	-
Шивээговь	242.0	-	104.5	1,354.5	1,701.0	1,701.0	-
Баянтал	83.4	12.4	1.3	299.1	396.2	946.3	(550.1)
Сумдын дүн	642.7	12.5	141.5	3,722.2	4,518.9	5,068.9	(550.1)

Эх сурвалж: Сангийн яамнаас ирүүлсэн орлогын шилжүүлгийн суурь тооцоолол, 2024 оны төсөв баталсан сумдын тогтоолууд

Сумдад ОНХС-ийн орлогын шилжүүлгийн санхүүжилт /итгэлцүүр/-ээс 3,722.2 сая, өмнөх жилийн төлөвлөлт, зарцуулалт, үйл ажиллагааны үнэлгээ 642.7 сая АМ-ын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр 12.5 сая, АМ-ын ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр 141.5 сая төгрөг нийт 4,518.9 сая төгрөгийг хуваарилсан байна. аймгийн ОНХС-д хуваарилсан орлогын шилжүүлгээс Баянтал сумын ОНХС-д 550.1 сая төгрөгийг нэмж хуваарилан баталсан байна.

Сумдад нийт 5,068.9 сая төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөсөн боловч гүйцэтгэлээр 4,930.2 сая төгрөгийг хуваарилсан байна.

Хүснэгт №02 Сумдын ОНХС-ийн санхүүжилтийн төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төгрөгөөр/

Санхүүжилт	Мөнгөн дүн /сая төгрөгөөр /			Нийт дүн
	Сүмбэр сум	Шивээговь сум	Баянтал сум	
Төлөвлөгөө	2,421.6	1,701.0	946.3	5,068.9
Гүйцэтгэл	2,345.6	1,638.3	946.3	4,930.2
Зөрүү	76.0	62.7	-	138.7

Эх сурвалж: ОНХС-ийн санхүүжилтийн төлөвлөгөө, гүйцэтгэлд хийсэн аудиторын тулгалт

Хүснэгтээс харахад сумдын ОНХС-ийн орлогын шилжүүлэг 138.7 сая төгрөг буюу 2.7 хувиар дутуу санхүүжсэн нь улсын төсвийн орлого бүрдүүлэлтээс шалтгаалсан байна.

¹ Аймаг, нийслэл нь Орон нутгийн хөгжлийн сангаас болон улсын төсвөөс олгосон шилжүүлгийг доор дурдсанаар сум дүүргийн Орон нутгийн хөгжлийн санд хуваарилна:

1.1.4 ОНХС-д хуульд заасан 3 нэр төрлийн эх үүсвэрээс нийт 485.7 сая төгрөгийг нэмж төлөвлөсөн байна.

Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2²-т зааснаар орон нутгийн хөгжлийн санд 2024 онд 485.7 сая төгрөгийн 3 эх үүсвэрийг нэмж төлөвлөсөн байна. Үүнд:

Дүрслэл №03 Орон нутгийн хөгжлийн санд нэмсэн орлогын эх үүсвэр

Төсвийн тухай хуулийн 60.2.8-д <i>"Малын тоо толгойн албан татварын орлого"</i>	•Малын тоо толгойн албан татварын орлого 163.1 сая
Төсвийн тухай хуулийн 60.2.4-д <i>"татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх болон зарлагыг хэмнэх замаар бий болгосон нэмэгдэл эх үүсвэр"</i>	•Сумдын 2023 оны давсан орлого, хэмнэгдсэн зардал 81.6 сая
Төсвийн тухай хуулийн 60.2.4-д <i>"татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх болон зарлагыг хэмнэх замаар бий болгосон нэмэгдэл эх үүсвэр"</i>	•ОНХО-ын хэрэгжүүлээгүй ажлын зардлын хэмнэлт 140.0 сая, давсан орлого 100.9 сая нийт 240.9 сая

Нэмж төлөвлөсөн эх үүсвэрийн Малын тоо толгойн албан татварын орлогын төлөвлөгөөний гүйцэтгэл 57.3 хувь, давсан орлого, хэмнэгдсэн зардлын төлөвлөгөөний гүйцэтгэл 95.8 хувьтай байна.

1.2 Сумын ОНХС-ийн төлөвлөлтийг хийхдээ иргэдийн санал аваагүй 1,170.3 сая төгрөгийн 13 төсөл, арга хэмжээг төлөвлөж батлуулсан байна.

1.2.1 ОНХС-ийн төлөвлөх үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн оролцоо сайжирсан хэдий ч аймгийн хэмжээнд иргэдийн санал аваагүй 13 ТАХ хэрэгжүүлэхээр баталсан нь төсөл, арга хэмжээний 11.4 хувь, батлагдсан төсвийн 11.9 хувийг эзэлж байна.

Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 5 дугаар зүйлийн 5.8³-д ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг ИНХ-аар хэлэлцүүлэхээр зохицуулсан бөгөөд МУЗЗНДНТУТХ-ийн 32 дугаар зүйлийн 32.6⁴-д заасны дагуу тооцоолоход хамгийн багадаа 1,147 иргэн ИНХ-д оролцсон тохиолдолд хуралдааныг хүчинтэйд тооцно гэж заасан байна.

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-ний саналыг журамд заасан хугацаанд багийн ИНХ-аар хэлэлцүүлсэн байна. Уг хурлаар нийт 1,324 иргэн оролцож санал өгсөн байна.

Хүснэгт №03. Багийн ИНХ-д оролцож санал өгсөн иргэдийн тоо

Сумын нэр	Санал өгсөн байвал зохих	Санал өгсөн иргэдийн тоо	Зөрүү
Сүмбэр	805	913	(108)
Баянтал	122	151	(29)
Шивээговь	220	260	(40)
Нийт дүн	1147	1324	(177)

² Орон нутгийн хөгжлийн сан нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

³ Ажлын хэсэг нь баг, хороодоос ирсэн саналыг нэгтгэж эрэмбэлэхдээ дараах үзүүлэлтүүдийг харгалзан зөвлөмж, дүгнэлт гарган сум, дүүргийн Засаг даргад хүргүүлнэ:

⁴ Тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн болон хорооны хэсэг тус бүрийн төлөөллийг хангах зарчмаар багийн иргэдийн Нийтийн Хурлын хуралдаанд гурван өрх тутмаас, 400-аас дээш өрхтэй багт таван өрх тутмаас, хорооны иргэдийн Нийтийн Хурлын хуралдаанд хорооны хэсэг тус бүрийн 20 өрх тутмаас, аймгийн төв, 20 мянгаас дээш хүн ам бүхий хот, суурин газрын иргэдийн Нийтийн Хурлын хуралдаанд 50 өрх тутмаас тус бүр нэгээс доошгүй хүн хүрэлцэн ирсэн тохиолдолд хуралдааныг хүчинтэйд тооцно. Иргэдийн Нийтийн Хурлын хуралдааны товыг хуралдаан болохоос ажлын таваас доошгүй өдрийн өмнө тухайн баг, хорооны оршин суугчдад мэдээлэх бөгөөд хуралдах байршил, цагийг тусгасан байна.

(Эх сурвалж: www.1212.mn, Багийн ИНХ-ийн тэмдэглэл, тогтоол)

Аймгийн хэмжээнд 10 багийн 1324 иргэнээс ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний нийт 147 саналыг гаргасан байна. Үүнээс сумын Засаг даргын захирамжаар батлагдсан ажлын хэсэг дараах байдлаар эрэмбэлсэн байна.

Дүрслэл №04 Ажлын хэсгийн эрэмбэлсэн саналыг сумдаар задалж харуулбал:

Сүмбэр сумын санал 913 иргэн	Шивээговь сумын санал 260 иргэн	Баянтал сумын санал 151 иргэн
- Давхардсан тоогоор 38 төсөл арга хэмжээний санал - Ажлын хэсгээс эрэмбэлсэн: 21 төсөл арга хэмжээ - Аймгийн ОНХС-аар хэрэгжүүлэх 9, УТХО-аар хэрэгжүүлэх 2 ТАХ-ний санал - Сумын ОНХС-аар 10 ТАХ-ний санал	- Давхардсан тоогоор 53 төсөл арга хэмжээний санал - Ажлын хэсгээс эрэмбэлсэн 19 төсөл арга хэмжээ - Аймгийн ОНХС-аар хэрэгжүүлэх 3, УТХО-аар хэрэгжүүлэх 2 ТАХ-ний санал - Сумын ИТХ-аар 14 төсөл арга хэмжээний санал	- Давхардсан тоогоор 56 төсөл арга хэмжээний санал - Ажлын хэсгээс эрэмбэлсэн 29 төсөл арга хэмжээ - Аймгийн ОНХС-аар хэрэгжүүлэх 3, УТХО-аар хэрэгжүүлэх 2 ТАХ-ний санал - Сумын ИТХ-аар 24 төсөл арга хэмжээний санал

(Эх сурвалж: 2023 оны багийн ИНХ-ын тэмдэглэл, ажлыг хэсгийн эрэмбэлсэн баримт)

Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 7 дугаар зүйлийн 7.6⁵-д зааснаар аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний нэгдсэн жагсаалтыг жил бүрийн 8 дугаар сарын 10-ны өдрийн дотор аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр заасан боловч хугацаа хоцроож 09 дүгээр сарын 02-нд хэлэлцүүлсэн байна.

Аймгийн хэмжээнд 2024 онд ОНХС-ийн хөрөнгөөр 9,853.6 сая төгрөгийн 114 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр аймаг, сумдын ИТХ-ын тогтоолоор баталсан байна.

Хүснэгт №04. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр баталсан хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний жагсаалт:

№	Нэр	ИТХ-ын тогтоолын огноо, дугаар	Төсөл арга хэмжээний тоо	Төсөв /сая төг/
1	Аймгийн ОНХС	2024.09.23 №03	30	3,064.5
2	Сүмбэр сумын ОНХС	2024.09.24 №03	35	3,317.9
3	Шивээговь сумын ОНХС	2024.09.24 №05	19	2,340.6
4	Баянтал сумын ОНХС	2024.09.25 №06	30	1,130.6
Нийт дүн			114	9,853.6

(Эх сурвалж: аймаг, сумдын ИТХ-ын тогтоол)

Сумдын ИТХ-ын тогтоолоор иргэдийн санал аваагүй 1,170.3 сая төгрөгийн 13 төсөл, арга хэмжээг баталсан нь ИТХ-аар баталсан нийт төсөл, арга хэмжээний 11.4 хувь, батлагдсан төсвийн 11.9 хувийг эзэлж байна. Үүнд: Шивээговь сум 278.0 сая төгрөгийн 3 төсөл, арга хэмжээ, Сүмбэр сум 892.3 сая төгрөгийн 10 төсөл, арга хэмжээг тус тус төлөвлөж батлуулсан байна.

Дүрслэл №05 Иргэдийн санал аваагүй ТАХ-ний жагсаалт:

⁵ Ажлын хэсэг нь баг, хороодоос ирсэн саналыг нэгтгэж эрэмбэлэхдээ дараах үзүүлэлтүүдийг харгалзан зөвлөмж, дүгнэлт гарган сум, дүүргийн Засаг даргад хургуулна:

Сүмбэр сум
/10/

1. Хуучин 2-р сургуулийн хичээлийн 2-р байрыг дотуур байр болгон засварлах ажил 585.0 сая
2. Энхтүсдэм ӨЭМТөвд шүдний кабинет байгуулах 44.1 сая
3. Цас арилгагч гар машин худалдаж авах 7.2 сая
4. Түүх соёлын үл хөдлөх дурсгалт газрын хяналт, шалгалт хийх автомашин худалдан авах 25.0 сая
5. 6-р цэцэрлэгийн гэр бүлэгт гэр худалдан авах 10.0 сая
6. Модны нүх урагч трактор худалдан авах 54.5 сая
7. Газар з/байгуулалт болон нэрийн тодруулалт хийх зардал 5.0 сая
8. Газарзүйн нэрийн тодруулалт хийх ажил 33.5 сая
9. Олон үйлдэлт шанагат ачигч худалдан авах 98.0 сая
10. 2-р цэцэрлэгт гал тогооны т.төх худалдан авах 30.0 сая

Шивээговь
сум
/3/

1. Нийтийн эзэмшлийн орон сууцны 3-р байрны техникийн давхрын шугам сүлжээний өргөтгөл, шинэчлэлийн ажил 150.0 сая
2. Төрийн байгууллагуудад шаардлагатай тех т.төх худалдан авах 108.0 сая
3. ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх дэд бүтцийн ажлын зураг төсөв 20.0 сая

(Эх сурвалж: сумдын ИНХ-ын тогтоол)

Иймд Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.6⁶, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 6 дугаар зүйлийн 6.4⁷, 7 дугаар зүйлийн 7.4⁸ дахь заалтуудыг зөрчиж, өмнөх аудитаар илэрсэн зөрчлийг давтан гаргасан тул Сүмбэр сум, Шивээговь сумын Засаг дарга нарт албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

1.2.2 ОНХС-аар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нийт төсөл, арга хэмжээний 95.0 хувь нь орон нутгийн хөгжлийн бодлого, чиглэлтэй уялдсан байна.

Аймгийн Засаг даргын “2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, сумын Засаг даргын “2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-тэй ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 114 төсөл, арга хэмжээний 108 төсөл, арга хэмжээ уялдаж, 6 төсөл, арга хэмжээ уялдаагүй байна.

Хүснэгт №05. “2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-тэй уялдаа

Батлагдсан төсөл, арга хэмжээний тоо	Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр		Сумдын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр	
	Уялдсан	Уялдаагүй	Уялдсан	Уялдаагүй
114	29	1	79	5

(Эх сурвалж: Аймаг, сумдын “2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”)

⁶ орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ

⁷ Ажлын хэсэг нь баг, хороодоос ирсэн саналыг нэгтгэж эрэмбэлэхдээ дараах үзүүлэлтүүдийг харгалзан зөвлөмж, дүгнэлт гарган сум, дүүргийн Засаг даргад хүргүүлнэ:

⁸ Аймаг, нийслэлийн Засаг дарга ажлын хэсгийн санал, дүгнэлтээр баталгаажсан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний саналыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан танилцуулна

Дүрслэл №06. Аймаг, сумын Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдаагүй нийт 6 төсөл, арга хэмжээг дүрслэлээр харуулав.

Аймгийн Засаг даргын “2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”

- Шивээговь суманд ахуйн үйлчилгээний барилгын холболтын зураг төсөв боловсруулах ажил- 25.0 сая төгрөг

Сүмбэр сумын “2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-

- Цас арилгач гар машин худалдаж авах- 7.2 сая төгрөг
- Түүх соёлын үл хөдлөх дурсгалт газрын хяналт, шалгалт хийх автомашин худалдан авах- 25.0 сая төгрөг
- Олон үйлдэлт шанагат ачигч худалдан авах- 98.0 сая төгрөг

Шивээговь сумын “2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”

- Цэцэрлэгийн хашааг шинэчлэн барих ажил- 160.0 сая төгрөг
- Сургуулийн спорт заалны их засвар- 179.1 сая төгрөг

Эх сурвалж: Аймаг, сумдын “2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”

1.2.3 Төсвийн тухай хуульд заасан төсөвлөлтийн шаардлагад нийцээгүй 2,305.3 сая төгрөгийн 9 төсөл, арга хэмжээг төлөвлөж, баталсан байна.

Аймгийн хэмжээнд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нийт 9,853.6 сая төгрөгийн 114 хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний Төсвийн тухай хуулийн 29^{1.2}-т заасан шаардлага, шалгууртай нийцэж байгаа эсэхийг үзэхэд 2,305.3 сая төгрөгийн 9 ТАХ-д төлөвлөлтийг бодитой хийгээгүй, зураг төсвийн тооцоолол дутуу, урьдчилсан судалгаа хийгдээгүй байна. Үүнд:

Аймгийн ОНХС:

- Сүмбэр сумын 1 дүгээр сургуулийн фасад засвар, спорт заалны дотор их засварын ажил-682.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлын зураг төсвийн гүйцэтгэгч тухайн орчин нөхцөлийг судлаагүйгаас ажлын тоо хэмжээ зөрүүтэй хийгдсэн. /Гадна пассад, агааржуулагч/

Сүмбэр сумын ОНХС:

- Хуучин 2-р сургуулийн хичээлийн 2-р байрыг дотуур байр болгон засварлах ажил /585.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй/ - тухайн ажлын зураг төсвийн гүйцэтгэгч тухайн орчин нөхцөлийг судлаагүйгаас ажлын тоо хэмжээ зөрүүтэй хийгдсэн. /Ариун цэврийн өрөөний плита, шал/
- Түүх соёлын үл хөдлөх дурсгалт газрын хяналт шалгалт хийх авто машин худалдан авах /25.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй/ - тухайн ажлын барааны эдийн засгийн урьдчилсан судалгааг хийгдээгүйгээс тендерийг 2 удаа зарлаж, цаг хугацаа алдсан

Шивээговь сумын ОНХС:

- Сумын 1-р багт хийгдэх нийтийн биеийн тамирын талбай байгуулах ажил /248.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй/ - техникийн тодорхойлолт дахь ажлын тоо хэмжээ дутуу, ажлын төсөв тооцоолол буруу хийгдснээс чанаргүй ажил бий болсон. /Хөл бөмбөгийн талбайн хөвөөг төлөвлөөгүй /
- Сургуулийн спорт заалны их засвар /179.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй/ - ажлын зураг төсвийг гүйцэтгэгч тухайн орчин нөхцөлийг судлаагүй тул ажлын тоо хэмжээ зөрүүтэй хийгдсэн. /шал өөрчилсөн, хананы заслыг 2 дахин хийсэн/
- Төрийн албан хаагчдын амьдрах орчин нөхцлийг дэмжих /байр засварлах/ /276.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй/- техникийн тодорхойлолт дахь ажлын тоо хэмжээ дутуу, ажлын зураг төсвийг гүйцэтгэгч тухайн орчин нөхцөлийг судлаагүйгаас ажлын тоо хэмжээ зөрүүтэй хийгдсэн. /Агааржуулалтын хоолой, цонхны амлагаа, бохирын шугам төлөвлөөгүй, орон нутгийн орчин нөхцөлд тохирохгүй халаах хэрэгсэл/

Баянтал сумын ОНХС:

- 154-р байрны дээврийн засвар /79.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй/ - ажлын төсөв гүйцэтгэгч тухайн орчин нөхцөлийг судлаагүйгаас ажил чанаргүй хийгдсэн.
- Худаг шинээр гаргах ажил /30.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй/ - ажлын төсвийг гүйцэтгэгч тухайн орчин нөхцөлийг судлаагүйгаас ажлын тоо хэмжээ зөрүүтэй хийгдсэн. /төсвийг тооцоо судалгаагүй, хэт бага төлөвлөсөн/

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 29¹.2 дугаар зүйлийн 29.2.3⁹, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.1.3¹⁰-т заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд зураг төсөл боловсруулсан гүйцэтгэгч байгууллагуудтай гэрээ байгуулахдаа орон нутагт байгаа объект дээр ажиллуулаагүй, бодитой, иж бүрэн тооцоолоогүй, алдаатай зураг төсөв хүлээн авснаас шалтгаалан чанаргүй ажлууд хийгдсэн тул зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлагыг аймаг, сумын Засаг дарга нарт хүргүүлэв.

Аймгийн хэмжээнд ОНХС-ийн хөрөнгөөр баяр наадмын зардлыг Засгийн газрын 2010 оны 271 дүгээр тогтоолын зөрчиж, нийт 443.0 сая төгрөгөөр нэмж баталсан байна. Үүнд:

- Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр баяр наадмын зардлыг 410.0 сая,
- Шивээговь сумын ОНХС-ийн хөрөнгөөр баяр наадмын зардлыг 15.0 сая,
- Баянтал сумын ОНХС-ийн хөрөнгөөр баяр наадмын зардлыг 18.0 сая

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1¹¹, 14 дүгээр зүйлийн 14.2.3¹², Засгийн газрын 2010 оны 271 дүгээр тогтоолын “Жишиг хэмжээг шинэчлэн тогтоох тухай (Наадмын санхүүжилт)”-ын 1¹³-д заасныг тус тус зөрчсөн байна.

Цаашид холбогдох хууль эрх зүйн акт нь үнийн өсөлттэй холбоотой шинэчлэгдээгүй тул уг арга хэмжээний зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг хууль журамд нийцүүлэн оновчтой төлөвлөхийг аймаг, сумын Засаг дарга нарт зөвлөмж хүргүүлж байна.

1.2.4 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ТАХ нь холбогдох журамд заасан чиг үүрэгтэй нийцсэн байна.

Аймгийн хэмжээнд 2024 онд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөж баталсан 9,853.7 сая төгрөгийн нийт 114 ТАХ нь журамд заасан чиг үүрэгт нийцсэн байна. Үүнд:

Дүрслэл №07 ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн чиг үүрэг


⁹ 29¹.2.3.техник эдийн засгийн үндэслэл хийх шаардлагатай төсөл, арга хэмжээнд техник эдийн засгийн үндэслэл, урьдчилсан судалгааг хийлгэсэн байх;

¹⁰ 4.1.3.ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь хуульд заасны дагуу зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлтэй, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон байх;

¹¹ 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;

¹² 14.2.3.өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах;

¹³ Үндэсний их баяр наадмын арга хэмжээнд зориулан төсвөөс гаргах санхүүжилтийн жишиг дээд хэмжээг аймагт 10.0 (арван) сая төгрөг, суманд 5.0 (таван) сая төгрөг байхаар тус тус тогтоож



- Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, боловсрол, соёл, Инновац, шинжлэн ухаан, цахим технологи
- Дэд бүтцийг сайжруулах, зам, гүүр, далан шуудуу, цахилгаан, дулааны шугам сүлжээ
- Орчны тохижилт, ногоон байгууламж, байгаль орчныг хамгаалах
- Ундны усан хангамж, эрүүл ахуйг сайжруулах
- Аймаг, хотын хөгжлийн төлөвлөгөө, төсөл, хөтөлбөрийн ТЭЗҮ, зураг төсөв, боловсруулах
- Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх;
- Тэжээлийн нөөц бүрдүүлэх;
- Байгаль орчныг хамгаалах;
- Журамд заасан чиг үүрэгт хамааралгүй

(Эх сурвалж: Аймаг, сумдын чиг үүргийн нийцлийн судалгаа №08, 09)

Дүрслэлээс харахад Нийт хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний 31 хувийг орчны тохижилт, ногоон байгууламж, байгаль орчныг хамгаалах, 30 хувийг иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, боловсрол, соёл, инновац, шинжлэн ухаан, цахим технологи, 20 хувийг аймаг, хотын хөгжлийн төлөвлөгөө, төсөл хөтөлбөрийн ТЭЗҮ, зураг төсөв боловсруулах, 8 хувийг дэд бүтцийг сайжруулах, зам, гүүр, далан шуудуу, цахилгаан, дулааны шугам сүлжээ, 8 хувийг бусад чиг үүрэгт, 2 хувийг журамд заасан чиг үүрэгт хамааралгүй төсөл, арга хэмжээнд төлөвлөсөн байна.

БҮЛЭГ 2

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний зорилтод үр дүн 75.4 хувьтай байна

2.1. ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний 84.3%-д гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер зохион байгуулсан байна.

2.1.1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 140.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл арга хэмжээнд худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй, шууд гэрээ байгуулсан байна.

Тайлант онд шинээр хэрэгжих 9,142.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 101 хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар төлөвлөснөөс нийт 8,643.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 91 ТАХ-ний худалдан авах ажиллагааг амжилттай зохион байгуулж, 8,283.3 сая төгрөгийн гэрээ байгуулсан байна.

Хүснэгт №06. Тайлант хугацаанд гэрээ байгуулсан ТАХ-ний худалдан авах ажиллагааг сонгон шалгаруулалтын төрлөөр нь дараах хүснэгтээр харуулав.

№	ОНХС	/сая төгрөгөөр/									
		Гэрээ байгуулсан ТАХ: Үүнээс		НТШ		ХА		ШХА		Тендер зарлаагүй	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Аймаг	26	2,864.1	6	1,664.1	8	451.9	11	648.1	1	100.0
2	Сүмбэр	30	2,570.1	8	1,726.1	10	507.1	12	336.9		
3	Шивээговь	16	1,919.6	8	1,615.2	3	181.2	5	123.2		
4	Баянтал	19	929.5	1	595.3	7	245.5	10	88.7	1	40.0
Нийт дүн		91	8,283.3	23	5,600.7	28	1,385.7	38	1,156.9	2	140.0

(Эх сурвалж: Аудитын судалгаа, ХАА-ны тайлан)

ОНХС-ийн худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа төсөвт өртгийг жижиглэн хуваасан, босго үнийг баримтлаагүй, тендер зарлалгүйгээр 140.0 сая төгрөгийн 2 ажилд шууд гэрээ байгуулсан байна.

2024 онд нийт 56 төсөл, арга хэмжээнд тендер зарлахаас 77 удаагийн худалдан авах ажиллагаа зохион байгуулан 51 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх гүйцэтгэчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулсан байна. Худалдан авах ажиллагаа зохион байгуулсан боловч шаардлага хангасан гүйцэтгэгч шалгараагүй 434.3 сая төгрөгийн 5 ТАХ-ний худалдан авах ажиллагаа амжилтгүй болсон байна.

Шууд худалдан авалт хийхээр төлөвлөсөн 1,228.9 сая төгрөгийн 46 ТАХ-нээс 72.0 сая төгрөгийн 5 ТАХ нь эх үүсвэр бүрдээгүйгээс хэрэгжээгүй байна.

Аудитаар Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг баримталж ажиллаагүйгээс 1,911.5 сая төгрөгийн өртөг бүхий 13 төсөл, арга хэмжээтэй холбоотой дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

- **Аймгийн ОНХС:** 100.0 сая төгрөгийн өртөгтэй "Авто замын ус зайлуулах хоолой, шугамын ажил"-д тендер зарлаагүй, аймгийн Засаг даргын захирамжаар ажлын хэсэг байгуулагдаагүй байхад аймгийн ЗДТГ гүйцэтгэгчтэй шууд гэрээ байгуулан ажлыг гүйцэтгүүлсэн боловч гамшгийн болон онцгой нөхцөл байдал үүссэн талаар нотлох баримт байхгүй, баримт материалын бүрдүүлэлт цаг хугацааны хувьд өөр хоорондоо зөрүүтэй, уялдаагүй
- **Сүмбэр сумын ОНХС:** 44.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Энх тус дэм өрхийн эрүүл мэндийн төвд шүдний кабинет байгуулах" ажилд харьцуулалтын аргыг ашиглан 38.3 сая төгрөгөөр гэрээ байгуулан худалдан авалт хийсэн боловч нэмэлт гэрээгээр 5.8 сая төгрөгийн худалдан авалт хийсэн нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 36.1.3¹⁴ дахь заалтыг зөрчсөн
- **Сүмбэр сумын ОНХС:** -ТБОНӨХБАҮХАТ хуулийн 42 дугаар зүйлийн 42.1¹⁵ дэх заалтыг зөрчин гүйцэтгэгчтэй байгуулсан 528.2 сая төгрөгийн 4 ажлын гэрээнд гүйцэтгэлийн баталгааны баримт ирүүлэх тухай заалтыг тусгаагүй, хассан
- **Шивээговь сумын ОНХС-ТБОНӨХБАҮХАТ** хуулийн 42 дугаар зүйлийн 42.1¹⁶ дэх заалтыг зөрчин гүйцэтгэгчтэй байгуулсан 1,199.2 сая төгрөгийн 5 ажлын гэрээнд гүйцэтгэлийн баталгааны баримт ирүүлэх тухай заалтыг тусгаагүй, хассан

¹⁴ 36.1.3 нээлттэй тендер шалгаруулалтын аргаар худалдан авсан барааны нэмэлт нийлүүлэлт анхны гэрээний үнийн 20 хувиас хэтрэхгүй нөхцөлд анхны гэрээний дагуу нийлүүлсэн бараа, тоног төхөөрөмжийн зарим хэсгийг солих, засварлах болон нэмж нийлүүлэх үед нийлүүлэгчийг өөрчлөх нь захиалагч өөр төрлийн техникийн үзүүлэлттэй материал авахад хүргэх, энэ нь ашиглалт болон засвар үйлчилгээнд техникийн хүндрэл учруулах, эсхүл үргүй зардал гаргахаар бол;

¹⁵ 42.1.Тендер шалгаруулалтын төсөвт өртөг 100 сая төгрөгөөс дээш бол гэрээний үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гүйцэтгэлийн баталгаа шаардана.

¹⁶ 42.1.Тендер шалгаруулалтын төсөвт өртөг 100 сая төгрөгөөс дээш бол гэрээний үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гүйцэтгэлийн баталгаа шаардана.

- **Баянтал сумын ОНХС:** “Соёлын төвд ёс заншлын өргөө” худалдан авах 40.0 сая төгрөгийн ажлын төсөвт өртгийг гэрийн мод 20 сая, дээвэр, туурга 20 сая төгрөгөөр 2 хэсэгт хувааж, 1 иргэнтэй шууд гэрээ байгуулсан.


Эдгээр нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1¹⁷, 12 дугаар зүйлийн 12.1¹⁸, 36 дугаар зүйлийн 36.1.3¹⁹, 42 дугаар зүйлийн 42.1²⁰-д заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах талаар аймаг, сумдын Засаг дарга нарт зөвлөмж, зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулсан Үнэлгээний хороотой холбоотой дараах нийтлэг зөрчлүүд илэрлээ. Үүнд.

- 2024 онд зохион байгуулсан нийт тендерийн баримт бичгийн 50% нь баримтын бүрдэл дутуу
- Үнэлгээний хорооны гишүүнээр ажиллахаар зөвшөөрсөн болон ашиг сонирхлын зөрчилгүй мэдэгдэл дутуу,
- Тендер хянан үзэх хүснэгт, тендерийн нээлтийн тэмдэглэлд гарын үсэг дутуу зурсан
- Тендерийн баримт бичгийг аргачлалын дагуу боловсруулаагүй
- Техникийн тодорхойлолтыг хууль тогтоомж, батлагдсан заавар журмын хүрээнд бэлтгээгүй төсөл, арга хэмжээний баримт материалыг хүлээн авч үнэлсэн

Дүрслэл № 08 Тендер шалгаруулалтын ажлын баримтын бүрдүүлэлт



(Эх сурвалж: Худалдан авах ажиллагааны баримт, аудитын ажлын баримт)

Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа хууль, журмыг мөрдөж ажилладаггүй, хариуцсан мэргэжилтэн болон үнэлгээний хорооны гишүүдийн мэдлэг, чадвар дутмаг, хариуцсан ажилдаа хайнга ханддаг, үнэлгээний хорооны дарга болон гишүүдэд хариуцлага тооцдоггүй зэрэг нь зөрчил гарах шалтгаан болж зөрчил жил бүр давтагдсаар байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1²¹-д тендерийн баримт бичгийг аргачлалын дагуу боловсруулах, 48

¹⁷ 5.1. Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална.

¹⁸ 12.1. Захиалагч техникийн тодорхойлолтод бараа, ажил, үйлчилгээний шаардлагатай гэж үзсэн шинж чанар, түүний зориулалт болон зориулалтын дагуу ашиглахтай холбоотой шаардлага, зураг төсөл, холбогдох стандарт, норм, дүрэм, зааврыг тусгана.

¹⁹ 36.1.3. нээлттэй тендер шалгаруулалтын аргаар худалдан авсан барааны нэмэлт нийлүүлэлт анхны гэрээний үнийн 20 хувиас хэтрэхгүй нөхцөлд анхны гэрээний дагуу нийлүүлсэн бараа, тоног төхөөрөмжийн зарим хэсгийг солих, засварлах болон нэмж нийлүүлэх үед нийлүүлэгчийг өөрчлөх нь захиалагч өөр төрлийн техникийн үзүүлэлттэй материал авахад хүргэх, энэ нь ашиглалт болон засвар үйлчилгээнд техникийн хүндрэл учруулах, эсхүл үргүй зардал гаргахаар бол;

²⁰ 42.1. Тендер шалгаруулалтын төсөвт өртөг 100 сая төгрөгөөс дээш бол гэрээний үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гүйцэтгэлийн баталгаа шаардана.

²¹ 11.1. Тендер шалгаруулалтын баримт бичгийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан жишиг баримт бичиг, маягт, гэрээний нөхцөл болон холбогдох журам, аргачлалын дагуу боловсруулж, захиалагч батална.

дугаар зүйлийн, 48.4²², 48.5²³-д баримт бичгийн бүрдлийг ханган архивын нэгж үүсгэх талаар заасан байна.

Иймд худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа хууль, журмыг мөрдөж ажилладаггүй үнэлгээний хорооны дарга, гишүүдийн хариуцлагыг сайжруулах чиглэлээр тодорхой ажил зохион байгуулж ажиллахыг үнэлгээний хороодод үүрэг болгохыг аймаг, сумдын Засаг дарга нарт зөвлөмжөөр хүргүүлэв.

2.1.2. ОНХС-ийн хөрөнгийг бодит гүйцэтгэлтэй нийцээгүй 9 төсөл, арга хэмжээнд 204.6 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Аймгийн хэмжээнд 2024 онд ОНХС-ийн хөрөнгөөр шинээр хэрэгжүүлэх нийт 101 төсөл, арга хэмжээнд 9,142.3 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөснөөс 72.3 хувь буюу 6,699.0 сая төгрөгийн 73 төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжсэн ба 2,443.3 сая төгрөгийн 28 төсөл, арга хэмжээ он дамжин хэрэгжихээр дараа онд шилжсэн байна.

2024 онд ОНХС-ийн зарлагын гүйцэтгэл 8,150.6 сая төгрөг бөгөөд үүнээс нийт 104 хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний 7,759.0 сая төгрөгийг гүйцэтгэгчид, 103.0 сая төгрөгийг зохиогчийн хяналт, захиалагчийн хяналт хэрэгжүүлэгч байгууллагад, гэрээний алданги болох 20.6 сая төгрөгийг сумын орон нутгийн орлогын дансанд, 268.0 сая төгрөгийг барьцаа дансанд тус тус шилжүүлсэн бөгөөд нийт 1,360.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна.

ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний санхүүжилтийг олгохдоо гэрээний тусгай нөхцөлд заасан урьдчилгаа төлбөрийн хувь хэмжээг хэтрүүлсэн, хийсэн ажлын гүйцэтгэлийг бодит үнэлж, хяналт хэрэгжүүлээгүйгээс бодит гүйцэтгэлд үндэслэхгүйгээр нийт 9 төсөл, арга хэмжээнд 204.6 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон зөрчил илэрлээ. Үүнд: /Дэлгэрэнгүйг хавсралт №1-аас үзнэ үү/

- Аймгийн ОНХС-аас 2 ажлын санхүүжилт 53.9 сая,
- Сүмбэр сумын ОНХС 4 ажлын санхүүжилт 23.7 сая,
- Баянтал сумын ОНХС 3 ажлын санхүүжилт 127.0 сая

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1²⁴, 14 дүгээр зүйлийн 14.2.3²⁵, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.2.9²⁶-д заасныг тус тус зөрчсөн байна.

Цаашид төсвийн удирдлагыг хууль тогтоомж, дүрэм журмын дагуу үр нөлөөтэй хэрэгжүүлэх, урьдчилгаа төлбөрийг зөвхөн тендерийн баримт бичиг болон гэрээний тусгай нөхцөлд заасан /30 хувиас хэтрэхгүй/ нөхцөлөөс хэтрүүлэхгүй байх, санхүүжилтийг ажлын бодит гүйцэтгэлийг баталгаажуулсны дараа олгох албан шаардлагыг төсөв захирагч нарт хүргүүлэхээр шийдвэрлэв.

2.2 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 3,046.0 сая төгрөгийн 11 төсөл, арга хэмжээний чанар үр дүн хангалтгүй, үр өгөөж буурсан байна.

2.2.1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний зорилтот түвшин, үр дүндээ хүрээгүй төсөл, арга хэмжээ 28 буюу 24.6 хувийг эзэлж байна.

2024 онд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 114 төсөл, арга хэмжээнээс 75.4% буюу 86 төсөл арга хэмжээ нь төлөвлөсөн хугацаандаа хэрэгжсэн, 15.8% буюу 18 төсөл, арга хэмжээ дутуу, 8.8% буюу 10 төсөл, арга хэмжээ огт хэрэгжээгүй байна.

²² 48.4.4.захиалагч, оролцогчтой харилцсан албан бичиг;

²³ 48.4.5.оролцогчдын ирүүлсэн тендер;

²⁴ 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;

²⁵ 14.2.3.өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах;

²⁶ 4.2.2.9.төсөл, арга хэмжээний санхүүжилт хүссэн гүйцэтгэлийн баримт бичиг, иж бүрдэл, түүний үнэн зөв эсэхэд бүрэн хариуцаж ажиллах

Хүснэгт №07. ОНХС-ийн төлөвлөгөөний хэрэгжилт

(Тоо, хувь)

№	Аймаг, нийслэл, сум, дүүрэг	ИТХ-аар батлагдсан хөтөлбөр, төсөл, арга хэмжээний тоо	Бүрэн хэрэгжсэн хөтөлбөр, төсөл, арга хэмжээний тоо		Дутуу болон хэрэгжээгүй арга хэмжээний тоо	Төлөвлөгөө- ний хэрэгжилт
			Өмнөх он	Тайлант он		
1	Сүмбэр сум	35	3	28	4	88.6%
2	Шивээговь сум	19	1	14	4	78.9%
3	Баянтал сум	30	8	19	3	90%
	Сумын дүн	84	12	61	11	86.9%
1	Аймгийн ОНХС	30	1	12	17	43.3%
	Нийт дүн	114	13	73	28	75.4%

(Эх сурвалж: Аймаг, сумын ИТХ-ын тогтоол, аудитын судалгаа-3)

ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний гүйцэтгэлийг аймаг, сумдаар нь харьцуулахад Сүмбэр сум 88.6%, Шивээговь сум 78.9%, Баянтал сум 90%, аймаг 43.3%-ийн хэрэгжилттэй байна.

Аймгийн хэмжээнд 18 төсөл, арга хэмжээ дутуу хэрэгжсэн ба аймгийн ОНХС-гийн 14, Сүмбэр суманд 2, Шивээговь суманд 2 4 төсөл, арга хэмжээ тус тус бүрэн хэрэгжээгүй байна. Энэ нь ХАА-г хуулийн хугацаанд зарлаагүй, гэрээний хугацаанд ажлыг гүйцэтгүүлээгүйгээс 2-3 удаа гэрээг сунгасан, эрх бүхий шийдвэр гараагүй удсанаас шалтгаалсан байна. /Дэлгэрэнгүйг хавсралт №2-оос үзнэ үү/ 1.

Иймд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнээс зорилтот үр дүндээ хүрээгүй ажлын шалтгаан нөхцөлийг тодорхойлж, тайлант онд төлөвлөсөн үр дүнд хүргэх ажлыг зохион байгуулахыг аймаг, сумдын Засаг дарга нарт зөвлөмж хүргүүлэв.

Тайлант хугацаанд 206.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 10 төсөл, арга хэмжээ нь огт хэрэгжээгүй /**АОНХС-3, Сүмбэр-2, Шивээговь 2, Баянтал-3**/ бөгөөд аймаг, Сүмбэр, Шивээговь сумын ОНХС-гийн 7 төсөл, арга хэмжээнд худалдан авах ажиллагааг удаа дараа зохион байгуулахад гүйцэтгэгч оролцоогүй, Баянтал сумын 3 төсөл, арга хэмжээний санхүүжилт бүрдээгүйгээс төөл, арга хэмжээг хэрэгжүүлэх боломжгүй болсон байна. /Дэлгэрэнгүйг хавсралт №3-аас үзнэ үү/.

Аймгийн хэмжээнд 1,908.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 15 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан хугацаанд зохион байгуулаагүйгээс төлөвлөсөн төсөл, арга хэмжээ тайлант онд бүрэн хэрэгжээгүй, он дамжсан байна. Үүнд: аймгийн ОНХС-5, Сүмбэр сумын ОНХС-3, Шивээговь сумын ОНХС-3, Баянтал сумын ОНХС-гийн 4 төсөл, арга хэмжээ байна. (Дэлгэрэнгүйг хавсралт №4 үзнэ үү)

Аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хуулийн хугацаанд зарлах, тайлант хугацаанд бүрэн хэрэгжүүлэх тухай зөвлөмжийг өмнөх аудитаар өгсөн боловч зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй, мөн Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3²⁷, 15 дугаар зүйлийн 15.4.1²⁸, 41 дүгээр зүйлийн 41.2.7²⁹, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1³⁰-т заасныг зөрчсөн тул Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хугацаанд худалдан авах ажиллагааг зохион байгуулах албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлэхээр шийдвэрлэв.

Аудитаар ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний чанар, үр дүнд хүрээгүй **3,046.0 сая төгрөгийн 11 төсөл, арга хэмжээтэй** холбоотой дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Аймгийн ОНХС: 973.4 сая төгрөгийн төсөв өртөгтэй 3 төсөл, арга хэмжээтэй холбоотой нийт 780.5 сая төгрөгийн 3 зөрчил илэрч, 779.3 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 1.2 сая төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэсэн.

²⁷ 14.2.3.өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах;

²⁸ 15.4.1.төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8–д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх

²⁹ 41.2.7.хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах.

³⁰ 13.1.1.батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусгах;

- Сүмбэр сумын 1 дүгээр сургуулийн фасад засвар, спорт заалны дотор их засварын 681.1 сая төгрөгийн төсөвтэй ажил. Аудитаар фасадны силиконыг барилгын булан хэсэгт чанаргүй хийсэн, тааз даац муутай, хананд гөлмөн төмрөөр агааржуулалтын систем хийхээр төлөвлөснөөс механик үйлчлэлийн нөлөөгөөр бэхэлгээ нь суларч унах эрсдэл үүссэн. Агааржуулалтын систем байнгын ажиллагаагүй, цонхны амалгаа хийгдээгүйгээс шалтгаалж цан цохиж, чийгтэй орчинд будаг замаск ховхорч заслын ажил үр дүнгүй болсон тул зөрчлийг арилгуулах албан шаардлага өгөхөөр шийдвэрлэлээ. Зураг 1



- Авто замын ус зайлуулах хоолой, шугамын 98.2 сая төгрөгийн өртөгтэй ажил. 2024.11.30-нд хүлээн авсан. Шалгалтаар ус хуримтлуулах, зайлуулах зориулалттай байгууламжийг бүрэн төлөвлөж хийгээгүйгээс хөвөө хэсэг усанд угаагдаж авто зам болон явган замын хийц бүтээцэд нөлөөлж болзошгүй нөхцөл үүссэн тул зөрчлийг арилгуулах албан шаардлага өгөхөөр шийдвэрлэлээ. Зураг №2



- Нийгмийн салбарын байгууллагуудыг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах 191.2 сая төгрөгийн төсөвтэй ажил - барааг 2024.10.15-нд ашиглагч байгууллагуудад хүлээн өгөхдөө БТСГ-т 2 нэр төрлийн 3 ширхэгийг хөрөнгийг хүлээлгэж өгөөгүй тул 1.2 сая төгрөгийг орон нутгийн орлогод төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэлээ.

Сүмбэр сумын ОНХС : 690.0 сая төгрөгийн төсөв өртөгтэй 3 төсөл, арга хэмжээтэй холбоотой нийт 617.4 сая төгрөгийн 3 зөрчил илэрч, албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэсэн. Үүнд:

- Хуучин 2-р сургуулийн хичээлийн 2-р байрыг дотуур байр болгон засварлах 582.1 сая төгрөгийн төсөвтэй ажлыг 2024.10.01-нд ажлын комисс хүлээн авсан байна. Аудитаар интернет сүлжээ, галын дохиолол, холболт хийгээгүй, ариун цэврийн өрөөнүүдийн хананд хийсэн плитаг бүрэн тэгш гадаргуу дээр наагаагүйгээс хөндийрч унах эрсдэлтэй болсон тул зөрчлийг арилгуулах албан шаардлага өгөхөөр шийдвэрлэсэн. Зураг №3




- Түүх соёлын үл хөдлөх дурсгалт газрын хяналт шалгалт хийх авто машин худалдан авах ажил нь 24.5 сая төгрөгийн төсөвтэй бөгөөд автомашины 2024.05.20-нд ажлын хэсэг болон ашиглагч байгууллага хүлээн авсан байна. Техникийн тодорхойлолтод заагдсан 15-тай дугуй, суудлын бүрээс болон шалавч ирээгүй, машин дээр лого байршуулаагүй зэрэг дагалдах хэрэгсэлүүдийг дутуу байхад хүлээн авсан тул зөрчлийг арилгуулах албан шаардлага өгөхөөр шийдвэрлэсэн.
- Төрийн байгууллагууд болон төрийн албан хаагчдад "Бид чадна" 2.5 сая, "Монгол бичигтэн 2025" 3.0 сая, "3 төрөлт тэмцээн" 2.3 сая, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэмцээнд 3.0 сая, нийт 10.8 төгрөгийг урамшуулалд зарцуулсан нь Сангийн сайдын 2021 оны 86 дугаар "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам" тушаалын 4 зүйлийн 4.7.6-д заасныг зөрчсөн тул ОНХС-ийн хөрөнгийг хууль журмаар хориглосон арга хэмжээнд зарцуулахгүй байх, зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

Шивээговь сумын ОНХС: 703.9 сая төгрөгийн төсөв өртөгтэй 3 төсөл, арга хэмжээтэй холбоотой нийт 696.0 сая төгрөгийн 3 зөрчил илэрч, албан шаардлага өгөхөөр шийдвэрлэсэн.

- Сургуулийн спорт залны их засвар 171.8 сая төгрөгийн төсөвтэй ажлыг 2024.10.25-нд ажлын хэсэг болон ашиглагч байгууллагын төлөөлөлтэй хүлээн авсан байна. Аудитаар ашиглагч байгууллагын зүгээс шалны хийц болон шалны хадаас, шаланд зай үүссэн талаар захиалагчид мэдээлэл хүргүүлсэн байна. Барилгын дээврээс ус гоожиж буй асуудлыг шийдвэрлэхгүйгээр дотоод заслын ажил төлөвлөснөөс заслын ажлыг 2 удаа гүйцэтгэсэн, Бетон шалны тэгшилгээ 6.5 м3, цонхны шилийг 3 давхраас 2, 300вт гэрэлтүүлгийг 100вт болгосон зэргээр ажлын тоо хэмжээнд өөрчлөлт оруулсан. Захиалагчид шалны хадаас, шалны зай үүссэн талаар гүйцэтгэгчид мэдэгдэл хүргүүлж баталгааны хугацаанд зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах албан шаардлагыг хүргүүлж байна. Зураг 4



- Төрийн албан хаагчдын амьдрах орчин нөхцлийг дэмжих /байр засварлах/ 276.0 сая төгрөгийн төсөвтэй ажлын 2024.11.05-нд ажлын хэсэг хүлээн авсан байна. Аудитаар ажлын тоо хэмжээнд өрөөнүүдийн агааржуулалт, цонхны амалгаа, бохирын шугам, дээврийн парпет төмөрлөх ажлыг тусгаагүй бөгөөд бохирын шугам болон парпет төмрийг магадлашгүй ажлын зардлаар хийлгэсэн. Харин агааржуулалт, цонхны амалгаа хийгээгүйгээс зарим өрөөнд цан цохиж ус гоожсон, ханын цаас хууларсан зөрчил илэрсэн тул зөрчлийг арилгуулах албан шаардлага хүргүүлэв. Зураг №5



- Сумын 1-р багт хийгдэх нийтийн биеийн тамирын талбай байгуулах 248.2 сая төгрөгийн төсөвтэй ажлыг 2024.08.20-нд ажлын хэсэг болон ашиглагч байгууллагын төлөөллүүд хүлээн авсан байна. Ажлын тоо хэмжээнд талбайг тойрсон хөвөө хэсгийг бетоноор хийх ажлыг оруулаагүйгээс дэвссэн хайрга нь ашиглалтын нөлөөгөөр талбайд тархсан, зүлэгний наалт хууларч унасан, гэрэлтүүлгийн удирдлагын самбарыг ашиглагч байгууллага зориулалтаар нь ашиглаагүй, хяналтын камер төлөвлөөгүйгээс хашааны тор эвдэрсэн, хөрөнгийн ашиглалт хадгалалт хамгаалалт хангалтгүй байгаа тул зөрчлийг арилгуулах албан шаардлага хүргүүлэв. Зураг №6



Баянтал сумын ОНХС: 678.7 сая төгрөгийн төсөв өртөгтэй 2 төсөл, арга хэмжээтэй холбоотой нийт 671.6 сая төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага өгөхөөр шийдвэрлэсэн.

- 154-р байрны 76.3 сая төгрөгийн төсөвтэй дээврийн засварын ажлыг 2024.09.30-нд ажлын хэсэг хүлээн авсан. Захиалагчийн хяналт хийгдээгүйн улмаас чанаргүй ажил хүлээн авч байрны дээврээс борооны ус дахин гоожсон тул зөрчлийг арилгуулах албан шаардлага хүргүүлэв. Зураг №7



- Спорт заалны барилга шинээр барих /суурь/ 595.3 сая төгрөгийн төсөвтэй ажлыг 2024.11.30-нд ажлын хэсэг хүлээн авсан байна. Аудитаар 1 дүгээр давхрын хойд хэсгийн багана дам нуруу хийгээгүй, суур, шалны нягтруулалт хангалтгүй, шал тэгш хэмтэй бус, суурь зарим газраараа овойсон бол зарим хэсгээр суулт өгч хэв гажилт үүссэн. Шалны дулаалгын хөөсөнцөр тэгш хэмтэй бус зарим хэсэгт газарт хүрэлцэхгүй, битум түрхлэг хийгээгүй, ус нэвтэрсэн, арматурыг хамгаалсан ороолт салхинд хийсч арматур зарим хэсэгт эзвэрсэн байна. Захиалагч гүйцэтгэгчтэй гэрээ байгуулахдаа тендерийн баримт бичигт заасан ажлын тоо хэмжээг өөрчилсөн. Захиалагч ил далд ажлын актыг баталгаажуулаагүй зөрчлүүд илэрсэн тул зөрчлийг арилгуулах албан шаардлага хүргүүлэв. Зураг №8



Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3³¹, 15 дугаар зүйлийн 15.4.1³² Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 4.1.18³³, 12 дугаар зүйлийн 12.1³⁴, 13 дугаар зүйлийн 13.1³⁵, Иргэний хуулийн 350 дугаар зүйлийн

³¹ 14.2.3.өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах;

³² 15.4.1.төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8–д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх

³³ 4.1.18.“техникийн тодорхойлолт” гэж захиалагч худалдан авах бараа, ажил, үйлчилгээний техникийн үзүүлэлт, үйлдвэрлэл, үйл ажиллагааны арга, технологи, түүнд тавих технологийн шаардлагыг тодорхойлсон бүрдүүлбэрийг;

³⁴ 12.1.Захиалагч техникийн тодорхойлолтод бараа, ажил, үйлчилгээний шаардлагатай гэж үзсэн шинж чанар, түүний зориулалт болон зориулалтын дагуу ашиглахтай холбоотой шаардлага, зураг төсөл, холбогдох стандарт, норм, дүрэм, зааврыг тусгана.;

³⁵ 13.1.Захиалагч оролцогчоос бараа, ажил, үйлчилгээний техникийн тодорхойлолтод нийцэх, эсхүл гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангах эсэхийг тогтоох шалгалт, туршилтыг эрх бүхий бие даасан этгээдээр хийлгэсэн нотлох баримт, эсхүл холбогдох мэдээлэл ирүүлэхийг шаардаж болно.

350.1³⁶, 351 дүгээр зүйлийн 351.1³⁷, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам" тушаалын 4 зүйлийн 4.7.6³⁸-д заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд дээрх 11 ажлын гүйцэтгэлтэй холбоотой нийт 2,765.5 сая төгрөгийн 11 зөрчил илэрснээс 1.2 сая төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт, 2,764.3 сая төгрөгийн 10 зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлагыг аймаг, сумдын Засаг дарга нарт хүргүүлэхээр шийдвэрлэв.

Цаашид ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх, хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний төлөвлөлтийг сайжруулах, төсвийн хөрөнгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, захиалагчийн хяналтыг үе шат бүрд үр дүнтэй хэрэгжүүлэх, хүлээн авах комисс ажилдаа хариуцлагатай хандаж, техникийн тодорхойлолттой нэг бүрчлэн тулгаж хүлээн авах, шаардлага хангаагүй ажил хүлээж авахгүй байх нь зүйтэй юм.

2.2.2 ОНХС-ийн хөрөнгөөр аймаг, суманд хэрэгжүүлсэн 2,929.9 сая төгрөгийн 30 төсөл, арга хэмжээнүүд нь орон нутгийн хөгжилд хувь нэмрээ өгсөн байна.

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр аймаг, сумын ИТХ-аар 9,853.7 сая төгрөгийн 114 хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээг баталж, хэрэгжүүлсэн байна.

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээг салбараар нь ангилж үзэхэд: дэд бүтэц, тохижилт, нийгмийн салбарт 75.0%-ийг, хөрөнгө оруулалтын шинж чанар агуулаагүй урсгал зардлын шинжтэй зардалд 25%-ийг зарцуулсан байна.

Дүрслэл:09 Хөрөнгө оруулалт хийгдсэн салбарын ангилал



ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн орон нутгийн хөгжилд хувь нэмэр өгөхүйц бодит үр дүнтэй **2,929.9 сая төгрөгийн дараах 30 төсөл, арга хэмжээнүүд** байна. Үүнд:

Аймгийн ОНХС 6 ажил /423.8 сая/:

ОНХС-ийн хөрөнгөөр Сүмбэр сумын шинээр олгогдсон суурьшлын бүсэд айл өрхүүд нэмэгдүүлэгдсэнтэй холбоотойгоор цахилгааны хүчдэл нэмсэн “Тагтын эгнээний 0.4 кВа-

³⁶ 350.1.Ажил гүйцэтгэгч нь дараахь үүрэг хүлээнэ: 350.1.1.гэрээнд заасан ажлыг тогтоосон хугацаанд гүйцэтгэх;

350.1.2.гүйцэтгэх ажлын мөн чанар, ажил гүйцэтгэгчийн хувийн байдалтай холбоотой биечлэн гүйцэтгэвэл зохих ажлыг биечлэн гүйцэтгэх;

350.1.3.дараахь тохиолдолд захиалагчид нэн даруй мэдэгдэх:

а/ ажил гүйцэтгүүлэхээр захиалагчийн шилжүүлсэн материал, ажил гүйцэтгэх аргын талаар захиалагчийн өгсөн зааварчилга нь ажлын чанар, үр дүнд муугаар нөлөөлөхөөр байвал;

б/ ажлын чанар, үр дүнд муугаар нөлөөлөхөөр, ажил гүйцэтгэгчээс үл хамаарах ямар нэгэн нөхцөл байдал бий болсон.

³⁷351.1.Захиалагч дараахь үүрэг хүлээнэ:

351.1.4.ажил гүйцэтгэгчийн тавьсан шаардлагын дагуу чанар муутай буюу шаардлага хангахгүй материалыг сольж өгөх, буруу зааварчилгаагаа өөрчлөх, ажлын чанар, үр дүнд муугаар нөлөөлөх бусад нөхцөл байдлыг арилгах талаар өөрөөс шалтгаалах бүхий л арга хэмжээ авах.

³⁸ 4.7.6.Аливаа аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд олгох буцалтгүй тусламж, дэмжлэг, тэтгэмж, урамшуулал.

ийн кабель сольж, Гашууны эгнээнд КПа барих ажил” ажлыг 132.9 сая төгрөгөөр хэрэгжүүлсэн бөгөөд шинэ суурьшлын бүсийн айл өрхүүдийн цахилгааны асуудал бүрэн шийдвэрлэсэн байна.

- Сүмбэр сумын шинэ суурьшлын бүсэд авто замтай болгох “Олон Улсын босоо тэнхлэгийн автозамаас Тагт, Гашууны эгнээ хүртэлх 450 м авто зам болон Цэргийн алдар хөшөөнөөс уулзварыг 4 замын уулзвар болгон хойд болон урд тэнхлэгт 850 м автозамын зураг төсөв боловсруулах ажил” 27.5 сая, Өгөөжийн уулзвараас 2 дугаар сургуулийн уулзвар хүртлэх авто замын зураг төсөв боловсруулах ажил 19.9 сая төгрөгийн зураг төсөв хийгдсэн байна. Боловсрол, нийгмийн салбарт хийгдсэн 243.5 сая төгрөгийн 3 ТАХ байна.

Сүмбэр сум ОНХС 12 ажил /1,171.6 сая/:

- ОНХС-ийн хөрөнгөөр Бурхант хэсгийн айл өрхийг цахилгаан эрчим хүчээр хангах ажлыг 195.5 сая, Тагтын эгнээнд инженерийн шугам сүлжээнд холбогдсон худаг хийх ажлыг 168.3 сая, аймгийн усан сангийн төмөргүйжүүлэгч төхөөрөмж суурилуулах ажлыг 118.4 сая, 1, 3 дугаар багийн нийтийн эзэмшлийн орон сууцны орчны хаалгыг кодтой хаалгаар солих ажил 49.6 сая, Гашуунаас коллежийн авто замын 1.5 км зайд аймгийн өнгө үзэмж нэмэгдүүлсэн морин хуурын дүрстэй 62ш гэрэлтүүлгийн шон 181.0 сая, 3*3 харьцаатай сагсан бөмбөгийн талбай хийх ажил 244.2 сая, нийт 957.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлуудыг хэрэгжүүлсэн нь иргэдийн амьдралын орчин нөхцлийг сайжруулах, өнгө үзэмж нэмэхэд бодитой ажлууд болсон байна. Эрүүл мэнд, боловсролын салбарт хийгдсэн хөрөнгө оруулалт 214.7 сая төгрөгийн 6 ТАХ байна.

Шивээговь сум ОНХС 7 ажил /1,221.0 сая/:

- ОНХС-ийн хөрөнгөөр Сумын шинэ суурьшлын бүсэд худаг гаргах ажлыг 57.5 сая, нийтийн эзэмшлийн гудамж талбайн гэрэлтүүлгийн тоог нэмэгдүүлэх, засвар үйлчилгээний ажлыг 159.0 сая, нийтийн эзэмшлийн орон сууцны 3-р байрны техникийн давхрын шугам сүлжээний өргөтгөл, шинэчлэлийн ажлыг 147.8 сая, ус хангамжийн нэмэлт эх үүсвэр, шугам сүлжээ автоматжуулалтын ажлыг 375.4 сая, Хуучин хог хаягдал булшлах, шинээр хогийн цэг байгуулах ажлыг 234.5 сая төгрөгөөр шийдвэрлэсэн нь төвийн хог хаягдлын менежментийг сайжруулсан ажил болсон нийт 974.2 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлуудыг хэрэгжүүлсэн нь сумын иргэдийн амьдралын орчин нөхцлийг сайжруулахад бодитой хувь нэмэр болсон байна. Эрүүл мэнд, боловсролын салбарт хийгдсэн хөрөнгө оруулалт 246.8 сая төгрөгийн 2 ТАХ байна.

Баянтал сум ОНХС 5 ажил /113.5 сая/

- ОНХС-ийн хөрөнгөөр Талын илч ОНӨААТҮГ-ын дизель, 150кв зуухны цахилгаан нөөц үүсгүүр нөөцтэй болох ажлыг 39.9 сая төгрөгөөр хийсэн ба тог тасарсан ч уурын зуух зогсохгүй болсон, Худаг шинээр гаргах ажил 29.3 сая төгрөгөөр сумын иргэдийн хүнсний ногооны тарьдаг хүлэмжийг усалгаатай болсон, 04-06кв дэд станцын цахилгаан шугамын зураг 11.9 сая, нийт 81.1 сая төгрөгийн иргэдийн аюулгүй орчинд амьдрах хэрэгцээ шаардлагыг хангахад чиглэсэн ажил болсон байна. Боловсролын салбарт хийгдсэн хөрөнгө оруулалт 32.4 сая төгрөгийн 2ТАХ байна.

ОНХС-ийн хөрөнгөөр иргэдийн амьдралын орчин нөхцөлийг сайжруулах, эрүүл аюулгүй орчинд амьдруулах, орон нутгийн хөгжил цэцэглэлтэд бодитой хувь нэмэр болохуйц хөрөнгө оруулалт, арга хэмжээнд зарцуулах, иргэд олон нийтийн хүртэж буй үр өгөөжийг нэмэгдүүлэх нь ОНХС-ийн зорилготой нийцэж байгаа юм.

2.3. ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон хөрөнгө оруулалтын ажлуудад ашиглалт, хадгалалт, хамгаалалтгүй хөрөнгүүд бий болсон байна.

2.3.1 Аймгийн хэмжээнд ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжсэн төсөл, арга хэмжээний хүрээнд бий болсон 1,758.0 сая төгрөгийн 6 нэр төрлийн хөрөнгийг бүрэн хүчин чадлаар нь ашиглаагүй байна

2024 онд аймгийн хэмжээнд ОНХС-ийн хөрөнгөөр нийт 8,150.6 сая төгрөгийн 86 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлснээс 19 ТАХ-ний хүрээнд урсгал зардалд 1,377.5 сая, он дамжсан 18 ажлын

санхүүжилтэд 1,074.5 сая төгрөг зарцуулж, 67 төсөл, арга хэмжээний хүрээнд нийт 5,698.4 сая төгрөгийн хөрөнгө бий болсон байна.

Хүснэгт №08. Тайлант онд бүрэн хэрэгжсэн ТАХ-ний хүрээнд бий болсон хөрөнгийг зориулалтын дагуу ашигласан байдал

(Тоогоор)

№	Аймаг, сум	Бүрэн хэрэгжсэн хөтөлбөр, төсөл, арга хэмжээний тоо		Урсгал зардлын ТАХ	Зориулалтын дагуу ашиглаж байгаа хөрөнгө /ТАХ/	Ашиглалтын явцад гэмтэл эвдрэл үүссэн хөрөнгө /ТАХ/
		Өмнөх он	Тайлант он			
1	Сүмбэр сум	3	28	10	20	1
2	Шивээговь сум	1	14	4	9	2
3	Баянтал сум	8	19	4	21	2
	Сумын дүн	12	61	17	50	5
1	Говьсүмбэр аймаг ОНХС	1	12	1	11	1
	Нийт дүн	13	73	19	61	6

(Эх сурвалж: АИТХ тогтоол, сумдын ЗД захирамж, аудитын судалгааны №12 маягт)

Хүснэгтээс харахад: 67 төсөл, арга хэмжээний хүрээнд нийт 5,698.4 сая төгрөгийн хөрөнгөөс 61 ТАХ-ний хүрээнд бий болсон 3,940.4 сая төгрөгийн хөрөнгийг зориулалтын дагуу ашиглаж байгаа бол 8.9 хувь буюу 6 ТАХ-ний 1,758.0 сая төгрөгийн хөрөнгө ашиглалтын явцад эвдрэл, гэмтэл үүссэнээс бүрэн хүчин чадлаар ашиглаагүй байна. Үүнд:

Аймгийн ОНХС

- “Авто замын ус зайлуулах хоолой, шугамын ажил”-98.2 сая төгрөг

Сүмбэр сумын ОНХС

- “Хуучин 2-р сургуулийн хичээлийн 2-р байрыг дотуур байр болгон засварлах ажил”-579.1 сая төгрөг

Шивээговь сумын ОНХС

- “Сумын 1-р багт хийгдэх нийтийн биеийн тамирын талбай байгуулах ажил”-245.1 сая,
- “Сургуулийн спорт залны их засвар”-168.8 сая,

Баянтал сумын ОНХС

- “154-р байрны дээврийн засвар”-76.3 сая,
- “Спорт заалны барилга шинээр барих /суурь/”-590.5 сая

Цаашид ОНХС-гийн хөрөнгийг хөрөнгө оруулалтын шинжтэй төсөл арга хэмжээнд зарцуулснаар иргэд олон нийтийн хүртэж буй үр өгөөжийг нэмэгдүүлэх боломжтой байна.

Аудитаар Сүмбэр сумын ИТХ-аар хөрөнгө оруулалтын жагсаалтад автомашин авах зардал батлагдаагүй байхад Сүмбэр сумын ОНХС-гийн Гамшгаас хамгаалах хөтөлбөр, арга хэмжээний зардлаас 99.5 сая төгрөгөөр авто машин худалдан авсан бөгөөд ОНХС-ийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.1³⁹, 60.3.4⁴⁰, 60.3.6⁴¹, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны

³⁹ 60.3.1.орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргээс бусад хөтөлбөр, арга хэмжээ.

⁴⁰ 60.3.4.нийтийн эрх ашигт нийцээгүй үйл ажиллагаа

⁴¹ 60.3.6.орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ.

журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.7.3⁴², 4.7.5⁴³, 11 дүгээр зүйлийн 11.1⁴⁴, 11.2⁴⁵ дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна. ИТХ-аар батлуулаагүй хөрөнгө оруулалтыг хөтөлбөрөөс худалдан авалт хийхгүй байх, зориулалт бусаар зарцуулахгүй байх албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

2.3.2 ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний хүрээнд бий болсон 835.6 сая төгрөгийн 2 хөрөнгийн хадгалалт, хамгаалалт хангалтгүй байна.

Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 9 дүгээр зүйлийн 9.12-д *“ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон барилга байгууламж, тоног төхөөрөмж, эд хөрөнгийг хуульд заасны дагуу өмчлөлд бүртгэж авсан байгууллага нь ашиглалт, хадгалалт, хамгаалалтын зардлыг хариуцна”* гэж заасан байна.

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний үр дүнд бий болсон нийт 8,150.6 сая төгрөгийн 86 төсөл, арга хэмжээний хүрээнд бий болсон 5,698.4 сая төгрөгийн хөрөнгийн ашиглагч байгууллагууд хөрөнгөөр хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна.

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний үр дүнд бий болсон хөрөнгийн хадгалалт, хамгаалалттай холбоотой нийт 835.6 сая төгрөгийн дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

Баянтал сумын ОНХС

ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон 590.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Баянтал сумын спорт заалны суурийн ажил"-ыг ажлын хэсэг хүлээн авсан боловч хөрөнгийн ашиглалт хадгалалт хамгаалалт хангалтгүй байна. Спорт заалны суурийн ажлыг бүрэн дуусаагүй байхад ажлыг хэсэг хүлээн авч, сумын ЗДТГ-ын дансанд бүртгэсэн ба суурь хазайсан, завсар гарсан хэсгээр ус орсон байдалтай, барилга барих боломжгүй нөхцөл байдал үүссэн.

Шивээговь сумын ОНХС

ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон "Шивээговь хөл бөмбөгийн талбай"-г 245.1 ажлын хэсэг хүлээн авсан боловч хөрөнгийн ашиглалт хадгалалт хамгаалалт хангалтгүй байна. /хөл бөмбөгийн талбайн хөвөөг төлөвлөөгүйгээс хайрга асгасан ба ашиглалтын нөлөөгөөр хөвөөний хайрга зүлгэн дээр тархсан, зүлэгний наалт хууларсан, гэрэлтүүлгийн удирдлагын самбарыг ашиглагч байгууллага 1 жилийн хугацаанд зориулалтаар нь ашиглаагүй, хяналтын камер төлөвлөөгүйгээс хашааны тор эвдэрч, сэтэрсэн/

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24⁴⁶, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 11 дүгээр зүйлийн 11.1⁴⁷, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 5 дугаар зүйлийн 5.5.1⁴⁸-д заасныг тус тус зөрчсөн байна.

⁴² 4.7.3. Нийтийн эрх ашигт нийцээгүй үйл ажиллагаа

⁴³ 4.7.5. Орон нутгийн иргэдийн саналыг аваагүй орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ;

⁴⁴ 11.1. ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, зарцуулалт, тайлагналт, бүртгэл, хяналт болон эцсийн үр дүнг тухайн шатны төсвийн ерөнхийлөн захирагч бүрэн хариуцна

⁴⁵ 11.2. ОНХС-ийн төсөв боловсруулах, батлах, зарцуулах, тайлагнах, бүртгэх, хяналт тавих, зохион байгуулахад хууль тогтоомж зөрчсөн бол тухайн байгууллага, албан тушаалтанд Төсвийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ

⁴⁶ 4.1.24 "төсвийн хөрөнгө оруулалт" гэж улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг

⁴⁷ 11.1 ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, зарцуулалт, тайлагналт, бүртгэл, хяналт болон эцсийн үр дүнг тухайн шатны төсвийн ерөнхийлөн захирагч бүрэн хариуцна

⁴⁸ 5.5.1 Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу төрийн болон орон нутгийн өмч байх буюу төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг байнгын ашиглалтад хүлээн авсан, тоног төхөөрөмж хүлээн авсан акт болон зураг төсөл, ТЭЗҮ-г захиалагч хүлээн авсны дараа төрийн болон орон нутгийн өмчид бүртгүүлнэ

Иймд ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн арга хэмжээний хүрээнд бий болсон хөрөнгийг бүртгэлд бүрэн тусгах, үнэн зөв тайлагнах, хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах тухай албан шаардлагыг Шивээговь, Баянтал сумын Засаг дарга нарт хүргүүлэхээр шийдвэрлэв.

БҮЛЭГ 3

ОНХС-гийн үйл ажиллагаанд тавих хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүй, иргэд олон нийтэд ил тод тайлагнаагүй байна.

3.1 Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэлийн явцад хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлж ажиллаагүй байна

3.1.1. Аймаг, сумдын ИТХ нь ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-ний үе шат бүрд хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүй байна

Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.3⁴⁹, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.4⁵⁰-т заасны дагуу аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас ОНХС-гийн үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт шалгалт хийх эрх зүйн зохицуулалттай байна. Тус байгууллагаас аймаг, сумдын 2024 оны ОНХС-гийн зарцуулалтад дотоод хяналт хэрэгжүүлж 14,618.7 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 4,692.2 сая төгрөгийн албан шаардлага, 1.9 сая төгрөгийн төлбөрийн акт, 9,924.6 сая төгрөгийн зөвлөмж өгч хэрэгжилтийг тооцож ажилласан байна.

Хүснэгт №09. Санхүүгийн хяналт, дотоод аудитын газраас ОНХС-гийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалт

(сая төгрөгөөр)

ОНХС	Хяналт шалгалтын хамарсан хугацаа	Илрүүлсэн зөрчил				Эрсдэлийн үнэлгээ
		Албан шаардлага	Зөвлөмж	Төлбөрийн акт	Нийт	
Аймаг	2022-2024.03	126.2	6,889.6		7,015.8	Их эрсдэлтэй
Сүмбэр	2023-2024.07	4,566.0		0.2	4,566.2	Их эрсдэлтэй
Шивээговь	2022-2024.07		3,018.2	1.6	3,019.8	Дунд эрсдэлтэй
Баянтал	2022-2024.07		16.8	0.07	16.8	Бага эрсдэлтэй
Нийт		4,692.2	9,924.6	1.9	14,618.7	

(Эх сурвалж: СХДАГ-ын хяналт шалгалтын тайлан)

Төсвийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.1⁵¹, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3 дугаар зүйлийн 3.2.2⁵² 9.4⁵³-т заасны дагуу аймаг, сумын ИТХ нь ОНХС-гийн үйл ажиллагааны бүх үе шатанд хяналт тавих зохицуулалттай байна.

Аймаг, сумдын ИТХ-аас хэрэгжүүлсэн хяналтыг ирүүлсэн нотлох баримтаар авч үзвэл:

⁴⁹ 69.3.Дотоод аудитад төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагааг хамаарна.

⁵⁰ 9.4.ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэл болон энэ журмын хэрэгжилтэд төв, орон нутгийн хууль, хяналт, дотоод ба хөндлөнгийн аудитын байгууллага, аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын дэргэдэх хороо болон иргэд, иргэний нийгмийн байгууллагууд Төрийн аудитын тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Засгийн газрын 2015 оны "Дүрэм батлах тухай" 483 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Дотоод аудитын дүрэм" болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжид заасан чиг үүргийн дагуу хяналт тавина.

⁵¹ 64.1.1.Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэлэлцэн батлах, хэрэгжилтэд хяналт тавих;

⁵² 3.2.2.Тухайн шатны ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих;

⁵³ 9.4.ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэл болон энэ журмын хэрэгжилтэд төв, орон нутгийн хууль, хяналт, дотоод ба хөндлөнгийн аудитын байгууллага, аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын дэргэдэх хороо болон иргэд, иргэний нийгмийн байгууллагууд Төрийн аудитын тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Засгийн газрын 2015 оны "Дүрэм батлах тухай" 483 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Дотоод аудитын дүрэм" болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжид заасан чиг үүргийн дагуу хяналт тавина.

Аймгийн ОНХС

Аймгийн ИТХ-ын дарга 2024.11.01-ний өдрийн 91 тоот захирамжаар 7 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсгийг байгуулж, 2023, 2024 онд Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжсэн 17 төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн явцад хяналт шалгалт хийж шалгалтын үр дүнгээр цаашид анхаарах асуудлыг тодорхойлж, АИТХ-ын даргад танилцуулсан байна. Үүнд:

- 1.Аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих, үр дүнг нээлттэй тайлагнаж байх.
- 2.Хурлын даргын захирамжаар байгуулсан ажлын хэсэг бүх төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг хамруулах
- 3.АИТХ-аар батлагдсан ОНХС-гийн тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтэд төлөөлөгчид жил бүр хяналт тавих, дутуу болон хэрэгжээгүй ажлуудын гүйцэтгэлийг сайжруулах, төсвийн үр ашгийг нэмэгдүүлэхэд анхаарах
- 4.Захиалагчийн хяналтыг сайжруулах

Сүмбэр сумын ОНХС

- Сумын ИТХ-ын зөвлөл, Төсөв, санхүү, эдийн засгийн хөгжлийн хорооны хамтарсан хяналтыг ИТХ-ын хуралдаанаар хагас, бүтэн жилээр, зөвлөлийн хуралдааны явцад 3 удаа, биечлэн 1 удаа нийт 22 төсөл, арга хэмжээний хэрэгжилттэй танилцаж хяналт тавьсан байна.

Шивээговь сумын ОНХС

- Шивээговь сумын ИТХ-ын 2024.02.05-ны өдрийн “Хяналтын бүлэг томилох тухай” 08 дугаар тогтоолоор хяналтын 3 бүлэг томилж, сумын ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжиж буй 16 төсөл арга хэмжээнд хяналт хэрэгжүүлсэн байна.

Баянтал сумын ОНХС

- Баянтал сумын ИТХ-аас ОНХС-гийн 2024 оны үйл ажиллагаанд хяналт хэрэгжүүлээгүй тул уг зөрчлийг арилгаж хуулийн дагуу хяналт хэрэгжүүлэх, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ

Аймаг, сумын ИТХ-аас ОНХС-гийн үйл ажиллагаанд хийсэн хяналтын үр дүнгээр илэрсэн алдаа, зөрчлийг арилгуулах, холбогдох байгууллага албан тушаалтанд үүрэг болгож хэрэгжилтийг тооцох үйл ажиллагааг зохион байгуулаагүй байна. Мөн Шат шатны ИТХ-аас төсөв батлахдаа ОНХС-гийн төлөвлөлтийн үе шатанд хяналт хэрэгжүүлдэггүйгээс ОНХС-гийн чиг үүрэгт хамааралгүй, урьдчилсан тооцоо судалгаагүй, төслийн бэлэн байдал хангагдаагүй төсөл, арга хэмжээ батлагдах шалтгаан болж байна.

ОНХС-гийн хяналтыг төлөвлөлтийн үе шатанд буюу ИТХ-аар төсөв батлахад хэрэгжүүлж илэрсэн зөрчил дутагдлыг нь залруулах, төлөвлөлтийн шаардлага хангахгүй, ОНХС-гийн чиг үүрэгт хамааралгүй төсөл, арга хэмжээ батлахгүй байх, явцын хяналтаар илэрсэн зөрчлийг холбогдох байгууллага албан тушаалтанд албан бичгээр хүргүүлж үр дүнг тооцсоноор хяналт үр дүнтэй цогц байдлаар хэрэгжиж төсвийн хөрөнгийн төлөвлөлт, гүйцэтгэл сайжирч, үр ашиг нь дээшлэх боломжтой байна.

Иймд аймаг, сумын ИТХ-д ОНХС-гаас хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ төлөвлөлтийн шаардлага хангасан эсэхийг хянах, гүйцэтгэлийн хяналтаар илэрч байгаа зөрчлийг таслан зогсоох зөвлөмж, дүгнэлт гаргаж, нотлох баримтаар дэмжигдэхүйц хяналтын тайланг гаргаж холбогдох байгууллага албан тушаалтанд албан бичгээр хүргүүлж, хэрэгжилтийг тооцдог байх зөвлөмжийг хүргүүлэхээр шийдвэрлэв.

3.1.2 Хяналт хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий мэргэжлийн байгууллагууд хяналтыг чанартай, үр дүнтэй хэрэгжүүлээгүйгээс төсвийн хөрөнгө үр дүнгүй зарцуулагдах, ард иргэдийн хүртэх үр өгөөж буурч байна.

Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.19⁵⁴, Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоол “Барилгын ажлын захиалагчийн дүрэм”-ийн 3.12⁵⁵-т заасны дагуу барилгын ажлын

⁵⁴ 37.1.19.барилгын ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, фото зургаар баримтжуулан, ил, далд ажлын актыг баталгаажуулах;

⁵⁵ “Улсын болон орон нутгийн төсөв, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр орон нутагт баригдах барилга байгууламжийн захиалагчийн хяналтыг тухайн аймаг, нийслэлийн газрын харилцаа, барилга, хот байгуулалтын асуудал хариуцсан нэгжээр гэрээний үндсэн дээр төлөөлүүлэн гүйцэтгүүлж болно.”

гүйцэтгэлд захиалагч буюу түүнтэй гэрээний үндсэн дээр аймгийн ГХБХБГ-аас хяналт тавих чиг үүрэгтэй байна.

ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлсэн 101 ТАХ-нд 8,150.6 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон. Хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээнд хууль дүрмийн дагуу захиалагчийн хяналт хэрэгжүүлэх шаардлагатай 5,501.7 сая төгрөгийн 29 хөрөнгө оруулалтын ажил байна.

Хүснэгт №10. Захиалагчийн хяналтын мэдээ

ОНХС-н нэр	Захиалагчийн хяналт хэрэгжүүлбэл зохих ХО-ын тоо	Хяналт хэрэгжүүлсэн ХО-ын ажлын тоо	Хяналт хэрэгжүүлээгүй ажлын тоо
Аймаг	6	5	1
Сүмбэр ОНХС	9	9	0
Шивээговь ОНХС	9	8	1
Баянтал ОНХС	5	2	3
Нийт	29	24	5

(Эх сурвалж: ГХБХБГ-ын захиалагчийн хяналтын тайлан)

Хүснэгтээс харахад: Захиалагчийн хяналт хэрэгжүүлвэл зохих 29 ажлаас 24 буюу 82.7 хувьд нь хяналт хэрэгжүүлсэн байна. Өмнөх аудитаар Шивээговь, Баянтал сум захиалагчийн хяналтгүй ажиллаж байсан бол 2024 оноос захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж эхэлсэн байна.

Захиалагч байгууллага хяналт хэрэгжүүлээгүй 361.3 сая төгрөгийн 5 төсөл арга хэмжээ байна. Үүнд:

- **Аймгийн ОНХС:** 1. Аймгийн төвийн камержуулалтыг нэмэгдүүлэх, сайжруулах ажил-146.9 сая
- **Шивээговь сум:** 2. Нийтийн эзэмшлийн гудамж талбайн гэрэлтүүлгийн тоог нэмэгдүүлэх, засвар үйлчилгээний ажил-111.3 сая
- **Баянтал сум:** 3. Баяр наадмын талбайг шинээр барих 32.5 сая, 4. Баяр наадмын талбайг өргөтгөх ажил-41.3 сая, 5. Худаг гаргах ажил-29.3 сая

Аудитаар захиалагчийн хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүй 1,308.4 сая төгрөгийн 4 төсөл арга хэмжээтэй холбоотой дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Баянтал сум-Спорт заалны барилга шинээр барих /суурь/ 595.2 сая-ГХБХБГ хяналт үр дүнтэй бус, ил далд ажлын актыг үйлдэж баталгаажуулаагүй.
2. Баянтал сум-154-р байрны дээврийн засвар 76.3 сая -ГХБХБГ хяналт үр дүнтэй бус, ил далд ажлын актыг үйлдэж баталгаажуулаагүй.
3. Баянтал сум-Худаг шинээр гаргах ажил 29.3 сая-БТЗДТГ хяналт хэрэгжүүлээгүй сая, ил далд ажлын актыг үйлдэж баталгаажуулаагүй.
4. Аймгийн ОНХС-Сүмбэр сумын 1 дүгээр сургуулийн фасад засвар, спорт заалны дотор их засварын ажил-607.6 сая-ГХБХБГ-ын хяналт үр дүнгүй.

Энэ нь Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.19⁵⁶, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.2.1⁵⁷, 4.4.2⁵⁸, 4.3.5.7⁵⁹, 5

⁵⁶ 37.1.19.барилгын ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, фото зургаар баримтжуулан, ил, далд ажлын актыг баталгаажуулах;

⁵⁷ 4.2.2.1 Төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг батлагдсан төсөвт өртөг, гэрээний нийт дүн, холбогдох норм, нормативын баримт бичиг, тухайн барилгын ажлын батлагдсан зураг төсөл болон төсөв, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнд тусгасан барилгын ажлын үе шатны хуваарь, санхүүжилтийн хуваарийн дагуу тулган шалгаж, хянан баталгаажуулах

⁵⁸ 4.4.2 Төсөл, арга хэмжээг хуулиар баталсан хугацаанд бүрэн ашиглалтад оруулахад захиалагчийн техник, технологийн хяналтын чиг үүргийг гэрээний дагуу үр ашигтай, үр дүнтэй хэрэгжүүлэх.

⁵⁹ 4.3.5.7 Захиалагчийн хянан баталгаажуулсан ил, далд ажлын акт

дугаар зүйлийн 5.3.1⁶⁰-т заасны дагуу захиалагч болон захиалагчийн хяналт барилгын ажлын гүйцэтгэлд хяналт тавих, ил, далд ажлын актыг баталгаажуулах чиг үүргийг хэрэгжүүлээгүй байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжиж буй төслүүдийн чанар, үр дүн хангалтгүй байгаа тул хяналтын ажлыг сайжруулах, илэрсэн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлагыг Баянтал сумын Засаг дарга болон ГХБХБГ-т хүргүүлэхээр шийдвэрлэв.

3.1.3 Өмнөх аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт 78 хувьтай байна.

2024 онд Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын нэгдсэн удирдамжаар ОНХС-гийн 2023 оны орлогын бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитаар нийт 346.4 сая төгрөгийн 15 зөрчил илрүүлж, 346.4 сая төгрөгийн 14 зөрчилд албан шаардлага, сахилгын хариуцлага тооцуулах 1 албан шаардлага, 14 зөвлөмж өгсөн байна.

Аудитын шийдвэрийн хэрэгжилтийг үнэлэхэд 346.4 сая төгрөгийн 13 албан шаардлага, 10 зөвлөмж бүрэн хэрэгжиж, биелэлт 78 хувьтай, хэрэгжээгүй 2 албан шаардлага, 4 зөвлөмж байна.

Хүснэгт №11.Өмнөх аудитаар өгсөн аудитын шийдвэрийн хэрэгжилт /аймаг, сумдаар/

№	Аймаг, сумын нэр	Өгсөн албан шаардлага		Албан шаардлагын хэрэгжилт			Өгсөн зөвлөмж		Зөвлөмжийн хэрэгжилт			дундаж хувь
		Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүнгийн биелэлт	Хэрэгжилтийн хувь	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүнгийн биелэлт	Хэрэгжилтийн хувь	
1	Сүмбэр сум	3	51.8	2	51.8	67%	3	0	0	0	0%	33%
2	Шивээговь сум	3	32	3	32	100%	3	0	3	0	100%	100%
3	Баянтал сум	5	124.2	4	124.2	80%	3	0	3	0	100%	90%
4	Говьсүмбэр аймаг	4	138.3	4	138.3	100%	5	0	4	0	80%	90%
	нийт дүн	15	346.3	13	346.3	87%	14	0	10	0	70%	78%

(Эх сурвалж: Шалгадагч байгууллагуудаас ирүүлсэн албан бичиг, хэрэгжилтийг тооцох нотлох баримт)

Сүмбэр сумын Засаг дарга өмнөх аудитаар илэрсэн зөрчлийг арилгуулахаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг ирүүлээгүй байна.

Иймд Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020.12.09-ний өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.10⁶¹-т заасны дагуу зөрчлийг арилгах албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

Цаашид төсөв захирагч нар хөндлөнгийн болон дотоод аудитаар илэрсэн зөрчлийг давтан гаргахгүй байх, өгсөн зөвлөмжийг цаг хугацаанд нь хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах шаардлагатай байна.

3.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-ний мэдээллийг Удирдлага мэдээллийн системд ил тод бүрэн тайлагнаагүй, хэрэгжилтийн тайланг холбогдох байгууллагад хүргүүлээгүй байна.

3.2.1 ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хэрэгжилтийн тайлан нэгтгэж холбогдох байгууллагад хүргүүлээгүй, дүн шинжилгээ хийгээгүй байна.

⁶⁰ 5.3.1.Захиалагч болон захиалагчийг төлөөлж захиалагчийн техник, технологийн хяналтыг гэрээгээр гүйцэтгэж буй байгууллага нь төсвийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэж байгаа барилга байгууламж, их засварын ажилд захиалагчийн хяналтыг тавьж, хэмжилт шалгалтыг Барилгын тухай хууль болон холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, норм, стандартад заасны дагуу хэрэгжүүлнэ;

⁶¹ Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол

Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.2⁶²-д зааснаар Сүмбэр сум 2025.01.23-ны өдрийн А/47, Шивээговь сум 2025.01.28-ны өдрийн 01/58, Баянтал сум 2025.01.24-ний өдрийн 22 дугаар албан бичгээр 2024 оны ОНХС-ийн хэрэгжилтийн тайланг аймгийн ХБТХОХ-т тус тус хүргүүлсэн байна.

Гэвч аймгийн ХБТХОХ нь журмын 9 дүгээр зүйлийн 9.9⁶³-д зааснаар 2024 оны аймаг, сумдын ОНХС-ийн хэрэгжилтийн жилийн эцсийн тайланг нэгтгээгүй, Сангийн яаманд тайлан хүргүүлээгүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Аймаг, сумдын ОНХС-ийн хэрэгжилтийн тайланг нэгтгэж холбогдох байгууллагад хүргүүлээгүй нь ОНХС-ийн үйл ажиллагааг сайжруулах, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар нэгдсэн дүн дүгнэлт хийхгүй байгааг харуулж байна.

Аймгийн ХБТХОХ нь өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан тул албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

3.2.2 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж дууссан төсөл, арга хэмжээний 94.0%-ийг ашиглагч байгууллагуудын дансанд бүрэн тусгасан байна.

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний үр дүнд бий болсон хөрөнгийг аймгийн ИТХ-ын тогтоол, сумдын Засаг даргын захирамжаар холбогдох байгууллагуудын хөрөнгөд бүртгүүлсэн байна. 63 төсөл арга хэмжээний хүрээнд нийт 5,241.6 сая төгрөгийн ашиглагч байгууллага хөрөнгөд, 22 төсөл арга хэмжээний 1,377.5 сая төгрөгийн урсгал зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна.

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн нийт 1,074.7 сая төгрөгийн 14 төсөл арга хэмжээ нь улирлаас шалтгаалан ажил хойшилсон, гэрээний хугацаа дуусаагүй, барилга хөгжлийн төвд хянан баталгаажуулалтын ажил удааширсан шалтгаанаар он дамжсанаас данс бүртгэлд тусгах боломжгүй байна.

Тайлант онд бүрэн хэрэгжиж дууссан боловч бүртгэлд тусгаагүй 456.8 сая төгрөгийн 7 нэр төрлийн 14 ширхэг хөрөнгө байна. Үүнд:

- Аймгийн ОНХС-ийн баяр наадмын зардлаас худалдан авсан 9.0 сая төгрөгийн 3 нэр төрлийн 10 ширхэг хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй
- Сүмбэр сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн нийт 419.9 сая төгрөгийн 2 ажил /Өлзийт суурьшлын бүсийн цахилгаан хангамжийг нэмэгдүүлэх, сайжруулах, Шинэ суурьшлын бүсэд цахилгаан татах ажил /Бурхант/ нийт 27.8 сая төгрөгийн 2 зураг төсвийг тус бүр данс бүртгэлд тусгаагүй.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24⁶⁴, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 11 дүгээр зүйлийн 11.1⁶⁵, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 5 дугаар зүйлийн 5.5.1⁶⁶-д заасныг тус тус зөрчсөн байна.

⁶² Сум, дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн тайланг гаргаж дараа оны 2 дугаар сарын 01-ний өдрийн дотор аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст хүргүүлэх ба энэ журмын 9.9-д заасан мэдээллийг багтаана

⁶³ Аймаг, нийслэлийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс нь аймаг, нийслэл, сум, дүүргийн ОНХС-ийн хэрэгжилтийн жилийн эцсийн тайланг нэгтгэж, жил бүрийн 3 дугаар сарын 10-ны өдрийн дотор Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын ОНХС-ийн асуудал хариуцсан нэгжид ирүүлэх бөгөөд тайланд дараах мэдээллийг тусгана.

⁶⁴ 4.1.24 “төсвийн хөрөнгө оруулалт” гэж улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг

⁶⁵ 11.1 ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, зарцуулалт, тайлагналт, бүртгэл, хяналт болон эцсийн үр дүнг тухайн шатны төсвийн ерөнхийлөн захирагч бүрэн хариуцна

⁶⁶ 5.5.1 Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу төрийн болон орон нутгийн өмч байх буюу төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг байнгын ашиглалтад хүлээн авсан, тоног төхөөрөмж хүлээн авсан акт болон зураг төсөл, ТЭЗҮ-г захиалагч хүлээн авсны дараа төрийн болон орон нутгийн өмчид бүртгүүлнэ

Иймд ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн арга хэмжээний хүрээнд бий болсон хөрөнгийг бүртгэлд бүрэн тусгах тухай албан шаардлагыг аймаг, Сүмбэр сумын Засаг дарга нарт хүргүүлэхээр шийдвэрлэв.

Аймгийн хэмжээнд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгийг ашиглагч байгууллагын данс бүртгэлд үнэн зөв тусгаагүй, алдаатай бүртгэсэн 1,604.3 сая төгрөгийн дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Сүмбэр, Шивээговь сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн нийт 1,564.3 сая төгрөгийн 8 ажлын хүрээнд бий болсон хөрөнгийг ашиглагч байгууллагын данс бүртгэлд тусгахдаа хийгдсэн ажлын тоо хэмжээгээр задалж бүртгэлгүй, бөөн дүнгээр тусгасан. /Дэлгэрэнгүйг хавсралт №5-аас үзнэ үү/
- Баянтал сумын ОНХС-гаас 40.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Соёлын төвд ёс заншлын өргөөтэй болох" төсөл арга хэмжээг төлөвлөж, 8 ханатай гэрийг худалдан авсан боловч сумын ЗДТГ-ын данс бүртгэлд тусгуулснаас сумын Соёлын төвд гэрийг хүлээлгэж өгөөгүй.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24⁶⁷, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2⁶⁸, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1⁶⁹ Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 11 дүгээр зүйлийн 11.1⁷⁰, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 5 дугаар зүйлийн 5.5.1⁷¹ -д заасныг тус тус зөрчсөн байна.

Цаашид ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж дууссан хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний хүрээнд бий болсон хөрөнгийг ашиглагч байгууллагын данс бүртгэлд хийгдсэн ажлын тоо хэмжээгээр нэг бүрчлэн задалж үнэн зөв бүртгүүлэх талаар аймаг, сумын Засаг дарга нарт зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

3.2.3. Удирдлагын мэдээллийн системд ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтын 36.3%-ийг огт мэдээлээгүй, өмнөх аудитаар илэрсэн зөрчлийг давтан гаргасан байна.

Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 10 дугаар зүйлд УМС-д сангийн хөрөнгийн зарцуулалт, үр дүнг мэдээлэхээр заасан байна. Горим, сорилын хүрээнд УМС-д оруулсан мэдээллийг тулган баталгаажуулахад дараах зөрчил илэрсэн. Үүнд:

- Аймаг, Сүмбэр, Шивээговь сум УМС-д 3,560.8 сая төгрөгийн гэрээний дүн, 2,828.2 сая төгрөгийн зарцуулалтыг дутуу мэдээлсэн, иргэдэд ил тод мэдээлээгүй, зөрчлийг давтан гаргасан

Хүснэгт №12 УМС-д мэдээлээгүй зөрчлийг аймаг, сумдаар задалж харуулбал:

Аймаг, сумын нэр	Батлагдс ан төсөв	Ил тод болгосо н	Мэдээлээг үй	Нийт гэрээни й дүн	Ил тод болгосо н	Мэдээлээг үй	Зарцуула лт	Ил тод болгосо н	Мэдээлээг үй
------------------------	----------------------	------------------------	-----------------	--------------------------	------------------------	-----------------	----------------	------------------------	-----------------

⁶⁷ 4.1.24. "төсвийн хөрөнгө оруулалт" гэж улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг;

⁶⁸ 18.2. Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана.

⁶⁹ 69.2 Заавал хөтлөх нягтлан бодох бүртгэлийн нийтлэг маягтаас гадна төрийн өмчийн хуулийн этгээдэд хөтлөгдвөл зохих мэдээ, тайлангийн маягт, аргачлалыг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батлан мөрдүүлж болно.

⁷⁰ 11.1. ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, зарцуулалт, тайлагналт, бүртгэл, хяналт болон эцсийн үр дүнг тухайн шатны төсвийн ерөнхийлөн захирагч бүрэн хариуцна.

⁷¹ 5.5.1. Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу төрийн болон орон нутгийн өмч байх буюу төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг байнгын ашиглалтад хүлээн авсан, тоног төхөөрөмж хүлээн авсан акт болон зураг төсөл, ТЭЗҮ-г захиалагч хүлээн авсны дараа төрийн болон орон нутгийн өмчид бүртгүүлнэ;

Аймаг	3,064.5	3,064.5	-	2,858.1	2,122.0	736.0	2,158.5	1,585.0	573.5
Сүмбэр	3,317.9	3,317.9	-	2,884.4	184.5	2,699.9	2,621.8	570.6	2,051.2
Шивээг вь	2,340.6	2,340.6	-	2,232.9	2,108.0	124.9	1,925.5	1,722.0	203.5
Баянтал	1,130.7	1,130.7	-	1,047.2	1,047.2	-	1,085.2	1,085.2	-
Нийт дүн	9,853.7	9,853.7	-	9,022.5	5,461.7	3,560.8	7,791.0	4,962.8	2,828.2

Эх сурвалж: УМС-д хийсэн аудиторын тулгалт

Мэдээлээгүй шалтгаан нөхцөлийг тодруулбал: Сангийн яам ОНХС-ийн УМС-д хяналт хэрэгжүүлээгүй, Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжиж байсан Тогтвортой амьжиргаа 3 төсөл дууссанаас хойш УМС-ийн ашиглалт, ОНХС хариуцсан албан хаагчид тогтвор суурьшилтай ажиллаагүй, ажилдаа хариуцлагагүй хандсан зэрэг нөхцөл байдалтай байна.

Энэхүү УМС-ийг бүрэн ашиглах нь хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих боломжтой болох, цаашид системээр дамжуулан мэдээллийн сан бүрдүүлэх, хуваарилалт төлөвлөлт хийх, ОНХС-ийн санхүүжилт, гүйцэтгэлийг удирдах, тайлагнах, үнэлэх зэрэг ач холбогдолтой юм. Иймд УМС-ийн ашиглалт, хэрэглээг нэмэгдүүлэх, хөгжүүлэлтийг сайжруулах, ач холбогдлыг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

ОНХС-ийн УМС-ийн ашиглалт, хөгжүүлэлтийг сайжруулах, хяналт хэрэгжүүлэх талаар Сангийн яаманд санал хүргүүлэх уламжлах саналаар тайланд оруулах, өмнөх аудитаар илэрсэн зөрчлийг давтан гаргасан, сангийн хөрөнгийн зарцуулалт, үр дүнг дутуу, иргэдэд ил тод мэдээлээгүй зөрчлийг арилгуулах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

3.2.4 ОНХС-гийн хөрөнгийн зарцуулалтыг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бүрэн мэдээлсэн байна.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1⁷², 6.3.9⁷³-д заасны дагуу ОНХС-ийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг цаг тухайд нь үнэн зөв, иж бүрэн мэдээлсэн байна.

Гүйцэтгэлийн аудитаар нийт 1,949.0 сая төгрөгийн 25 зөрчил илрүүлж 1,947.8 сая төгрөгийн 19 зөрчилд албан шаардлага, 1.2 сая төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, аймаг, сумдын ИТХ-ын дарга, Засаг дарга нарт 5 зөвлөмж өглөө.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

1. ОНХНС-гаас орлого дутуу ирсэнээс шалтгаалан аймаг, сумдын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг бүрэн олгоогүй, Төсвийн тухай хуульд заасан 3 нэр төрлийн эх үүсвэрээс орлогыг нэмж төлөвлөсөн байна.
2. ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулсан хэдий ч иргэдийн саналгүй нийт **1,170.3 сая төгрөгийн 13 төсөл, арга хэмжээг** төлөвлөж батлуулсан нь хууль журмын дагуу төлөвлөхгүй байгаатай холбоотой, Төсвийн тухай хуульд заасан төсөвлөлтийн шаардлага хангаагүй **2,305.3 сая төгрөгийн 9 төсөл, арга хэмжээг** төлөвлөж, батлуулсан байна.

⁷² 6.1.1 тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор

⁷³ 6.3.9 орон нутгийн хөгжлийн сангийн гүйцэтгэл

- ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн зарим, төсөл, арга хэмжээний 84.3%-д гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер зохион байгуулсан байна. Үнэлгээний хорооны дарга, гишүүдийн хариуцлагыг сайжруулах шаардлагатай байна.
- ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний зорилтот түвшин, үр дүндээ хүрээгүй төсөл, арга хэмжээ 28 буюу 24.6 хувийг эзэлж байгаа бол 3,046.0 сая төгрөгийн 11 төсөл, арга хэмжээний чанар үр дүн хангалтгүй, үр өгөөж буурсан байна.
- ОНХС-ийн хөрөнгөөр аймаг, суманд хэрэгжүүлсэн 2,929.9 сая төгрөгийн 30 төсөл, арга хэмжээнүүд нь иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, аюулгүй орчинд амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэх, дэд бүтэц, орчны тохижилтыг сайжруулах чиглэлээр орон нутгийн хөгжил дэвшилд хувьд нэмрээ оруулсан хөрөнгө оруулалтууд бий болжээ.
- ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжсэн төсөл, арга хэмжээний хүрээнд бий болсон 1,758.0 сая төгрөгийн 6 нэр төрлийн хөрөнгийг бүрэн хүчин чадлаар нь ашиглаагүй, хадгалалт, хамгаалалтгүй хөрөнгүүд бий болсон байна.
- Аймаг, сумдын ИТХ нь ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-ний үе шат бүрд хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүй, мэргэжлийн байгууллагууд хяналтыг чанартай, үр дүнтэй хэрэгжүүлээгүйгээс төсвийн хөрөнгө үр дүнгүй зарцуулагдах, ард иргэдийн хүртэх үр өгөөж буурч байна.
- ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээг журам, зааврын дагуу хугацаанд нь тайлагнасан боловч 456.8 сая төгрөгийн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй орхигдуулсан, 1,604.3 сая төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд үнэн зөв тусгаагүй, алдаатай бүртгэсэн байна.
- Аймаг, суманд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн нийт төсөл, арга хэмжээний 36.3 хувийг удирдлагын мэдээллийн системд мэдээлээгүй байна.

ЗӨВЛӨМЖ

Аймгийн, сумдын ИТХ-ын даргад:

- ОНХС-гаас хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ төлөвлөлтийн шаардлага хангасан эсэхийг хянах, гүйцэтгэлийн хяналтаар илэрч байгаа зөрчлийг таслан зогсоох зөвлөмж, дүгнэлт гаргаж, нотлох баримтаар дэмжигдэхүйц хяналтын тайланг гаргаж холбогдох байгууллага албан тушаалтанд албан бичгээр хүргүүлж, хэрэгжилтийг тооцдог байх

Аймаг, сумдын Засаг дарга нарт :

- ОНХС-ийн хөрөнгөөр баяр наадмын зардлыг төлөвлөхдөө Засгийн газрын 2010 оны 271 дүгээр тогтоолыг баримтлах
- ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнээс зорилтот үр дүндээ хүрээгүй ажлын шалтгаан нөхцөлийг тодорхойлж, тайлант онд төлөвлөсөн үр дүнд хүргэх ажлыг зохион байгуулах, худалдан авах ажиллагааг зохион

байгуулахдаа хууль, журмыг мөрдөж ажилладаггүй үнэлгээний хорооны дарга, гишүүдийн хариуцлагыг сайжруулах чиглэлээр тодорхой ажил зохион байгуулж ажиллахыг үнэлгээний хороодод үүрэг болгох

Сүмдын Засаг дарга нарт

1. Сүмдын тендер шалгарсан гүйцэтгэгчтэй гэрээ байгуулахдаа ерөнхий гэрээнд заагдсан 100.0 сая дээш худалдан авалтанд гүйцэтгэлийн баталгааны ирүүлэхийг шаардах
2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж дууссан хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээг ашиглагч байгууллагын данс бүртгэлд хүлээлгэн өгсөн хөрөнгө, хийгдсэн ажлын тоо хэмжээгээр нэг бүрчлэн задалж бүртгүүлэх, бүртгэлд хяналт хэрэгжүүлэх

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ УЛАМЖЛАХ САНАЛ

Аудитаар илэрсэн дараах асуудлуудыг шийдвэрлэх талаар холбогдох газарт уламжлуулах саналтай байна. Үүнд:

1. ОНХС-ийн Удирдлага мэдээллийн системийн ашиглалт хөгжүүлэлтийг сайжруулах, төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлийн тайлангийн системүүдтэй холбож уялдаа холбоог сайжруулах
2. Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-д арга хэмжээний төлөвлөлтийг тодорхой шалгуур үзүүлэлтийн дагуу хөрөнгө оруулалтын ажлаас тусад нь төлөвлөх нарийвчилсан журам шаардлагатай байгаа тул журамд нэмэлт өөрчлөлт оруулах замаар зохицуулалтын асуудлыг тусгах
3. Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-д 4.7.2-т заасан үндэсний баяр наадмын зардалд зарцуулах зардлыг төлөвлөхөд Засгийн газрын 2010 оны 271 дүгээр тогтоолтой нийцэхгүй байгаа, жил бүр зөрчил давтагдан гарах нөхцөл байдал бий болж байгаа тул журмын заалт, тогтоолын уялдаа холбоог харгалзан үзэх шаардлагатай байна

ШАЛГАГДАГЧ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР	ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН СҮМБЭР СУМЫН ЗАСАГ ДАРГА
Найрамдал хотхон, 3 дугаар баг, Сүмбэр сум, Говьсүмбэр аймаг, 42015 Утас/факс: (976) 7054 3118, Цахим шуудан: zdtg.gsa@gmail.com, Цахим хуудас: www.govisumber.gov.mn 2025.06.30 № 07/685 танай 2025.06.26 -ны № 237 -т	2 дугаар баг, Сүмбэр сум, Говьсүмбэр аймаг, 42017 Утас: 7054 3249, Цахим шуудан: info@sumber.gs.gov.mn, Цахим хуудас: www.sumber.gs.gov.mn 2025.06.30 № 4/402 танай -ны № -т
ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ	ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.САРАНТУЯА ТАНАА
"Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүн"-ийн гүйцэтгэлийн аудитын тайланг танилцаж, тайлбарыг хавсралтаар хүргүүлэв. Хавсралт № хуудастай.	Сүмбэр сумын 2024 оны "Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүн"-д хийсэн аудитын дүгнэлтэд дараах санал, тайлбарыг хүргүүлж байна. Хавсралт.....хуудастай.
ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА МАНХБАЯР	Э.ДАВААДОРЖ
Бүтээгч С.Б.Батбаяр Тайланг танилцаж, Тайланг дүгнэж, Баталгааныг өгсөн 2025.06.30	Бүтээгч С.Б.Батбаяр Саналтай танилцаж, Тайланг дүгнэж 2025.06.30
ГОВЬСҮМБЭР АЙМАГ ШИНЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГА	ГОВЬСҮМБЭР АЙМАГ БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГА
Нутгийн удирдлагын газар, 11 дүр баг, Шинээговь сум, Говьсүмбэр аймаг, 42030 Утас/факс: (976) 7054 6204 Цахим хуудас: www.shineegovi.gov.mn 2025.06.30 № 01/367 танай 2025.06.26 -ны № 237 -т	Лүн, Баянтал сум, Говьсүмбэр аймаг, 42040 Утас: 9411 3190, Цахим хуудас: www.bayantal.gs.gov.mn 2025.06.30 № 2/7 танай 2025.06.26 -ны № 237 -т
ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.САРАНТУЯА ТАНАА	АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ
Сумын "Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө"-д хийсэн хяналт шалгалтын тайланг танилцлаа. Тус шалгалтаар илэрсэн алдаа, зөрчилд холбогдох саналаа хавсралтаар хүргүүлэв. Хавсралт 3 хуудастай.	"ОНХС-ийн 2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцаж тайлбар хүргүүлэв. Хавсралт /6 хуудастай.
Ч.СУГАРМАА	Э.БАТТУЛГА
Бүтээгч С.Б.Батбаяр Саналтай танилцаж, Тайланг дүгнэж, Баталгааныг өгсөн 2025.06.30	Бүтээгч С.Б.Батбаяр Саналтай танилцаж, Тайланг дүгнэж, Баталгааныг өгсөн 2025.06.30

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА,
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР

Найрамдал хотон 3 дугаар баг
Сүмбэр сум, Говьсүмбэр аймаг 42015
Утас 7054 3387 Цахим шуудан govsumber@gazar.gov.mn
Цахим хуудас www.govsumber.gazar.gov.mn

2025.06.30 № 01/2025
танил -ны № -т

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.САРАНТУЯА ТАНАА

Орон нутгийн хөгжил сангийн 2024 оны
бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөөнд хийсэн
гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлд холбогдох
санал, тайлбарыг баримтуудын хамт хүргүүлэв.

Хавсралт.....хуудастай.



Аудитор
Б.Сарантуяа
Саналтай тайлангаар
тайлагч нөхцөл
2025.06.30 гаруулах

2025.06.30



ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2025 оны 07 сарын 01 өдөр

Дугаар А/21

Чойр

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, 20.4 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/106 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18 дугаар зүйлийн 18.9, 18.10 дахь заалт, "Эрх шилжүүлэх тухай" 2023 оны А/102 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтын 1.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт үр дүн, үр нөлөө"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газар болон аймаг, сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга нарт тус тус хүргүүлэхийг аудитор (С.Батцэцэг)-д даалгасугай.

3. Аудитаар өгсөн зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан хугацаанд, аудитын тайланд дурдагдсан зөрчлүүдийг арилган, зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, түүний үр дүнг 2026 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн дотор Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймаг, сумдын Засаг дарга нарт тус тус зөвлөсүгэй.

4. Аудитын шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг аудитор (С.Батцэцэг)-д үүрэг болгосугай.

5. Аудитын ажлын болон нотлох баримтыг 2025 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн дотор архивын нэгж болгон байгууллагын архивд хүлээлгэн өгөхийг аудитын баг (ахлах аудитор Б.Дарханбат, Б.Анхтуяа, аудитор С.Батцэцэг, Б.Соёлмаа)-т даалгасугай.

6. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер (Г.Наранбаяр)-т даалгасугай.



Б.САРАНТУЯА

D:\DOTOOD AJIL\TUSHAL.doc
422561043

Хавсралт № 1

гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээг хэтрүүлсэн, хийсэн ажлын гүйцэтгэлийг бодит үнэлээгүй

/сая төгрөг/

№	ОНХС	Хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	Гэрээний дүн	Гүйцэтгэлээр олгосон нийт санхүүжилт	Гэрээний дагуу олгох ёстой санхүүжилтийн хэмжээ	Зөрүү буюу илүү олгосон санхүүжилт	Тайлбар
1	АОНХС	Авто замын ус зайлуулах хоолой, шугамын ажил	100.0	100.0	70.0	30.0	40.0	70% урьдчилгаа олгосон
2	АОНХС	Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний тодотгол	74.0	69.9	34.9	21.0	13.9	50% урьдчилгаа олгосон
3	СОНХС	2025 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын ажлын зураг төсөв /ТЭЗҮ/ боловсруулах ажил	43.0	20.0	20.0	10.0	10.0	50% урьдчилгаа олгосон
4	СОНХС	Сансар болон 1 дүгээр цэцэрлэгийн камержуулалтын ажил	15.3	15.3	10.7	4.6	6.1	70% урьдчилгаа олгосон
5	СОНХС	6-р цэцэрлэгийн гэр бүлэгт гэр худалдан авах	10.0	10.0	7.0	3.0	4.0	70% урьдчилгаа олгосон
6	СОНХС	5-р сургуулийн коридорт вакум хаалтаар өрөө хийх ажил	18.0	18.0	9.0	5.4	3.6	50% урьдчилгаа олгосон
7	БТОНХС	Спорт заалны барилга шинээр барих	599.3	595.3	297.6	178.6	119.0	50% санхүүжилт олгосон
8	БТОНХС	Соёлын төв ёс заншлын өргөөтэй болох /гэрийн мод	20.0	20.0	10.0	6.0	4.0	50% урьдчилгаа олгосон
9	БТОНХС	Соёлын төв ёс заншлын өргөөтэй болох / дээвэр, туурга	20.0	20.0	10.0	6.0	4.0	50% урьдчилгаа олгосон
Нийт			899.6	868.5	469.2	264.6	204.6	

№	ОНХС	Хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	Ажил гүйцэтгэх хугацаа	Гүйцэтгэгч
1	АОНХС	Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний тодотгол	74.0	2024-04-05 2024-12-20 2025-04-01	Ланд овнер ХХК
2	АОНХС	Аймгийн төвийн камержуулалтыг нэмэгдүүлэх, сайжруулах ажил	200.0	2024-06-25 2024-12-25	Жавхлант хүслэн ХХК
3	АОНХС	Сүмбэр суманд нийтийн эзэмшлийн талбай, тохижилтын ажил /Гомбосүрэн ноёны талбай/	282.3	2024-10-02 2024-11-30	Топ универсал констракшн ХХК
4	АОНХС	Сүмбэр сумын 1 дүгээр сургуулийн фасад засвар, спорт заалны дотор их засварын ажил	682.0	2024-07-30 2024-09-30 2024-12-09 2025-05-10	Өрнөх бюлдинг ХХК
5	АОНХС	Аймгийн Боржигин өв музейн барилгын зураг төсөв боловсруулах ажил	50.0	2024-03-25 2024-08-10 2024-12-20 2025-06-30	Эрхэс констракшн ХХК
6	АОНХС	Цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламжийн тохижилтийн ажлын зураг төсөв боловсруулах ажил	35.0	2024-05-06 2024-07-06 2024-09-06 2024-11-06 2025-01-30	Сонголт дизайн ХХК
7	АОНХС	Олон Улсын босоо тэнхлэгийн автозамаас Тагт, Гашууны эгнээ хүртэлх 450 м авто зам болон Цэргийн алдар хөшөөнөөс уулзварыг 4 замын уулзвар болгон хойд болон урд тэнхлэгт 850 м автозамын зураг төсөв боловсруулах ажил	28.0	2024-03-27 2024-05-27 2024-11-28	Арт трасс ХХК
8	АОНХС	Найрамдал хотхоны авто замын ус зайлуулах зураг төсөв боловсруулах ажил	20.0	2024-04-17 2024-06-17	Гидродизайн инноваци ХХК
9	АОНХС	Найрамдал хотхоны байрнуудын дунд нэг маягийн хүүхдийн тоглоомын талбай, авто зогсоолын зураг төсөв боловсруулах ажил	12.0	2024-04-16 2024-06-14	Мандах товер констракшн ХХК
10	АОНХС	Сумдын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах ажил	93.0	2024-04-05 2024-12-20 2025-04-01	Ланд овнер ХХК
11	АОНХС	Усан спорт сургалтын төвийн засварын ажлын зураг төсөв боловсруулах ажил	20.0	2024-04-24 2024-06-24 2024-09-11 2024-12-16 2025-03-15	Сонголт дизайн ХХК
12	АОНХС	Шивээговь сумын төв дотор 2.4 км авто замын ажлын зураг төсөвт өөрчлөлт оруулах төсөв шинэчлэх	10.0	2024-11-09 2025.02.21	Ихэр мөнх ХХК
13	АОНХС	640 хүүхдийн сургууль, цэцэрлэгийн барилгын их засварын ажлын зураг төсөв боловсруулах	90.0	2024-11-13 2025-02-20	Эрхэс констракшн ХХК
14	АОНХС	Аймгийн төвийн авто замуудад үерийн ус зайлуулах хоолой хийх зураг төсөв боловсруулах	15.0	2024-10-31 2024-12-31	Гидродизайн Инноваци ХХК
Дүн			1,611.5		
15	Сүмбэр ОНХС	Газар зүйн нэрийн тодруулалт хийх ажил	33.5	2024.08.26 2025.03.31	"Тэгшхэм" групп

16	Сүмбэр ОНХС	Сумын өвс тэжээлийн аюулгүйн нөөц бүрдүүлэх	47.0	2024.12.18 2025.01.31	Сансинус ХХК
Дүн			80.5		
17	ШГОНХС	Нийтийн эзэмшлийн гудамж талбайн гэрэлтүүлгийн тоог нэмэгдүүлэх, засвар үйлчилгээний ажил	160.0	2024.09.232 025.05.31	Их хайрханы хишиг ХХК
18	ШГОНХС	Гэр хорооллын цэвэр, бохир усны шугам сүлжээний зураг төсөв	85.0	2024.12.062 025.05.10	Эрхэст констракшн ХХК
Дүн			245.0	0	0
Нийт			1,937.0		

Хавсралт №3

Огт хэрэгжээгүй ТАХ-ний жагсаалт

/сая төгрөг/

№	ОНХС	Хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний нэр	Төсөвт өртөг
1	АОНХС	Нийтийн эзэмшлийн талбайн засвар үйлчилгээний ажил	35.7
2	АОНХС	Жорлонгоо өөрчлө аян	52.0
3	АОНХС	Шивээговь суманд ахуйн үйлчилгээний барилгын холболтын зураг төсөв боловсруулах ажил	25.0
Дүн			112.7
4	Сүмбэр ОНХС	Нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн усалгааны систем хийх ажил	100.0
5	Сүмбэр ОНХС	Сууршлын бүсэд цэвэр усны шугам татах	221.6
Дүн			321.6
6	ШГОНХС	Байгаль орчин, эрүүл ахуй, орчны бохирдлыг бууруулах "Хоггүй сум" арга хэмжээ	20.0
7	ШГОНХС	Малын тоо толгойн албан татвараас малчдад зориулсан арга хэмжээ	45.00
Дүн			65.0
8	БТОНХС	Бэлчээрийн хортон мэрэгчтэй тэмцэх	3.0
9	БТОНХС	Мал хэмжилтийн багажтай болох	2.0
10	БТОНХС	Үржлийн малын үзлэг ангилал	2.0
Дүн			7.0
Нийт			506.3

Хавсралт №4

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн баримтлан 05 сарын 31-ны дотор худалдан авах ажиллагааг зохион ТАХ жагсаалт

/сая төгрөг/

№	ОНХС	Хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний нэр	Тендер зарласан огноо	Төсөвт өртөг
1	Аймаг	Тагтын эгнээний 0.4 кВа-ийн кабель сольж, Гашууны эгнээнд КПа барих ажил	2024.07.30	135.5
2	Аймаг	Сүмбэр суманд нийтийн эзэмшлийн талбай, тохижилтын ажил /Гомбосүрэн ноёны талбай/	2024.10.02	282.3
3	Аймаг	Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөр	2024.06.20	200.0
4	Аймаг	Аймгийн өвс, тэжээлийн аюулгүйн нөөц бүрдүүлэх	2024.10.08	70.0
5	Аймаг	640 хүүхдийн сургууль, цэцэрлэгийн барилгын их засварын ажлын зураг төсөв боловсруулах	2024.10.22	90.0
6	Сүмбэр	Газар зүйн нэрийн тодруулалт хийх ажил	2024.06.17	33.5
7	Сүмбэр	Олон үйлдэлт шанагат ачигч худалдан авах	2024.05.31	98.0
8	Сүмбэр	2-р цэцэрлэгийн гал тогооны төхөөрөмж худалдан авах	2024.10.03	30.0
9	Шивээговь	Шинэ суурьшлын бүсэд худаг гаргах	2024.10.03	60.0
10	Шивээговь	Нийтийн эзэмшлийн гудамж талбайн гэрэлтүүлгийн тоог нэмэгдүүлэх, засвар үйлчилгээний ажил	2024.09.23	160.0
11	Шивээговь	Гэр хорооллын цэвэр, бохир усны шугам сүлжээний зураг төсөв	2024.12.06	85.0
12	Баянтал	Спорт заалны барилга шинээр барих	2024.06.17	599.3
13	Баянтал	ЕБС-д мэдээлэл зүйн танимд тоног төхөөрөмж авах	2024.06.24	25.0
14	Баянтал	Соёлын төв ёс заншлын өргөөтэй болох /гэрийн мод	2024.11.14	20.0
15	Баянтал	Соёлын төв ёс заншлын өргөөтэй болох / дээвэр, туурга	2024.11.15	20.0
Нийт дүн				1,908.6

Хавсралт №5

Бөөн дүнгээр бүртгэсэн хөрөнгийн жагсаалт

/мянган төгрөг/

№	ОНХС	Төсөл арга хэмжээ	Бүртгэх дүн
1	Сүмбэр сум	3*3 харьцаатай сагсан бөмбөгийн талбай,	244,177.28
2	Сүмбэр сум	Гудамж, зам талбайн гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх	180,995.99
3	Шивээговь сум	Сумын 1-р багт хийгдэх нийтийн биеийн тамирын талбай байгуулах ажил	245,129.76
4	Шивээговь сум	Сургуулийн спорт залны их засвар	168,837.55
5	Шивээговь сум	Цэцэрлэгийн хашааг шинэчлэн барих	144,484.68
6	Шивээговь сум	Нийтийн эзэмшлийн орон сууцны 3-р байрны техникийн давхрын шугам сүлжээний өргөтгөл, шинэчлэлийн ажил	147,807.51
7	Шивээговь сум	Ус хангамжийн нэмэлт эх үүсвэр, шугам сүлжээ автоматжуулалтын ажил	375,409.14
8	Шивээговь сум	Шинэ суурьшлын бүсэд худаг гаргах	57,466.57
Нийт дүн			1,564,308.48